

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255014>

МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН ДОТООД ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ТУХАЙ АСУУДАЛД

Ю.Мөнх-Амгалан

Түлхүүр үг: харилцаа холбоо, гадаад харилцаа холбоо, дотоод харилцаа холбоо, уран зохиол, монголын уран зохиол

Keywords: interactions, external interactions, internal interactions, literature, Mongolian literature

Аливаа улс орны уран зохиолын гадагшаа болон дотогшоо холбогдон хандсан харилцаа хамаарлыг хамгийн ерөнхий байдлаар нь гадаад ба дотоод харилцаа холбоо гэж ангилж болно. Уран зохиолын гадаад харилцаа холбоо гэдэгт тухайн улсын уран зохиол гадаадын аль нэг орны уран зохиолтой эрт, эдүгээгийн ямар нэгэн холбоо харилцаатай хөгжиж ирснийг хамааруулна. Энэхүү харилцаа холбоог бас дотор нь харьцангуй байдлаар дорно дахины ба өрнө дахины уран зохиолын харилцаа холбоо гэж ялгаж болно. Монголын уран зохиолын хувьд эртнээс нааш ихэвчлэн дорно дахины улс орнуудын уран зохиолтой шууд, харин өрнө дахины уран зохиолтой дам холбоо харилцаатай хөгжиж иржээ. Монголын уран зохиолын гадаад харилцаа холбоог дорнын ба өрнийн улсуудын уран зохиолтой шууд болон дам холбогдох байдлаар нь ийнхүү ангилахын хамт энэ хоёр уран зохиолын хүрээгээр дам дамжин холбогдсон дэлхийн өөр тив, бүс нутгийн бусад улс орны уран зохиолын харилцаа холбоотой холбон нэгэн ерөнхий тогтолцоонд нь бас ялган хэлэлцэж болно.

Монголын уран зохиол ийнхүү өрнө, дорнын болон тэдгээрээр дамжуулан дэлхийн бөмбөрцгийн өөр бусад орны уран зохиолтой шууд ба дам аль нэг байдлаар харилцаа холбоотой байж болохын зэрэгцээ дотоод хүрээндээ мөн нэгэн адил тодорхой харилцаа холбоотой байдаг байна. Энэхүү гадаад ба дотоод харилцаа холбооны заагт, энэ хоёр соёл, утга зохиолын хүрээний завсрын талбай дээр тусгайлан авч үзмээр өвөрмөц зохиолууд бас байдаг бөгөөд үүнийг бид энэ удаа хувилбар зохиол хэмээн урьдчилсан байдлаар болзон нэрлэж байна. Гадаадын аль нэг улсын тодорхой зохиолоос уламжлагдсан, түүний Монгол дахь хожуу үеийн аман ба бичгийн хувилбар шинжтэй, ихэвчлэн дорно дахины, тэр дундаа энэтхэг, төвөдийн орноос эх улбаатай зохиолуудыг энд хамааруулах бөгөөд үүний хамгийн тодорхой нэгэн жишээ болох “Гэсэрийн тууж” нь “буриад, монгол, түвд, халимаг болон бусад хувилбартай билээ” (Түдэв, 1975:111). Үүнийг дэлгэрүүлбэл “... Монгол Гэсэрийн туужууд. 1. Бээжин барын Гэсэр, ... 2. Заяын хүрээний Гэсэр, ... 3. Монгол Лин Гэсэр, ... Буриад Гэсэрийн тууж. Түвд Гэсэрийн туужууд. 1. Дорнод түвдийн Гэсэр, ... 2. Өрнөд түвдийн Гэсэр, ... Түвд бичмэл Гэсэрийн туужнууд. 3.

Түвд бичмэл А Гэсэр, ... 4. Түвд бичмэл Б Гэсэр, ... 5. Түвд бичмэл В Гэсэр, ... Түвд бичмэл II б Гэсэр...” (Дамдинсүрэн 1956:6-17) гэх зэрэг болно.

Тэрчлэн “Гэсэрийн тууж”-ийн олон хувилбар нь бас амаар дамжин уламжлагдаж аман үлгэр үүсгэсэн байх бөгөөд аман зохиол судлаач, доктор Т.Баясгалан “Тэдгээр аман үлгэрүүдийг Гэсэрийн бичмэл хувилбаруудтай харьцуулж үзээд, агуулга, үйл явдлаар нь: Бичмэл Гэсэрийн туужийн үйл явдлыг товчлон өгүүлсэн үлгэрүүд: *Онин, Цэвэгдорж, Үлэмж нарын хувилбарууд*, Гэсэрийн бичмэлүүдээс гаралтай боловч ондоошсон аман үлгэрүүд: *Агваанаагийн хувилбар, “Урангуа дагина”, “Нусгай Жур”*, Бие даасан аман үлгэрүүд: *“Гэсэр хаан”* (2014:161) хэмээн ангилсан байна.

“Гэсэрийн тууж” нь хэдийгээр төвөд гаралтай ч гэсэн монгол нутагт эрт цагаас янагш өргөн тархаж монголжсоныг эхлээд тэмдэглэх хэрэгтэй. Энэ бол монгол зохиол боллоо гэсэн үг. Монголд ийнхүү өргөн тархаж байснаас үүдэн “Гэсэр”-ийн хэд хэдэн янзын хувилбар Монголд бий болсон юм. Үүнд: а/. Бээжин “Барын Гэсэр”..., б/. “Заяын Гэсэр” ..., в/ “Замлин Сэнчиний намтар буюу монгол Лин Гэсэр” ..., г/. “Номч хатны Гэсэр” ..., д/. Цэвээний “Гэсэрийн тууж” ..., е/. “Ойрд Гэсэр буюу тод үсгийн Гэсэр” ..., ё/. “Буриад Гэсэр”-ийн аман болоод бичгийн олон хувилбар бий” (Лочин, 2019:104-105). Бүр тодруулбал академич Ц.Дамдинсүрэнгийн “Монголын уран зохиолын харилцаа холбооны асуудалд” (Уб., 1987) хэмээх номын оршилд “Акад. Ц.Дамдинсүрэн утга зохиолын харилцааны талаарх бүтээлүүдээ ихэвчлэн Монголын хуучин уран зохиолын түүхийг бэлтгэх явцдаа чухамхан энэ зорилгод захируулан бичсэн юм. Ийм бүтээлийн дунд юуны түрүүнд энэтхэгийн утга зохиолын зарим дурсгал Монголын ахуй нөхцөлд хэрхэн идээшин зохицож, тус орны оюун санааны амьдралын хүртээл болсныг үзүүлсэн цуврал өгүүлэл, ном нэн сонирхолтой болжээ. /”Панчатантрын төвд монгол өгүүллэгийн цоморлогууд”, “Рамаана монголд”, “Бигармижид хааны тухай гурван ном” г.м./ Мөн энэ цувралд Ганжур, Данжур дахь уран зохиолын зүйлс, тэдгээрийн Монголд тархсан буюу боловсорсон хувилбарууд, улмаар дэлхийн олон улсад байдаг ижил төстэй өгүүлэгдэхүүнтэй тэдгээрийн хэв шинж ба гарваль зүйн талаар холбогдох байдал сэлтийг авч үзсэн “Туулайн тухай цадиг”, “Анчин хүү, тэнгэрийн дагины үлгэрийн хувьсал хөгжлийн түүх”, “Илбэчний үлгэр” зэрэг өгүүлэл нь багтах юм. Акад. Ц.Дамдинсүрэн Төвөд, Монголын утга зохиолын харилцааны асуудалд нэлээд бүтээлээ зориулжээ. Үүнд “Гэсэрийн туужийн гурван шинж”, “Зургадугаар далай лам Цанъянжамц”, “Төвдийн хуучин уран зохиол ба түүний монгол орчуулгын тухай” зэрэг бүтээлийг нь дурдах хэрэгтэй” (3-4 дэх тал) хэмээн онцлон тэмдэглэсэн нь бидний энд өгүүлэн буй зүйлд зохих баримт нотолгоо болж байна. Хувилбар зохиол нь ийнхүү Монголын уран зохиолын гадаад харилцаа холбооны үндсэн дээр гарч ирэн улмаар Монголын ард түмний дунд идээшин нутагшиж монгол зохиол мэт болсон байдаг. Энэ мэтчилэн энд өгүүлэн буй зүйлд хамаарах Энэтхэг, Төвөдийн уран зохиолтой холбогдол бүхий монгол уран зохиолын дэлгэрэнгүй тоймыг дор дурдсан бүтээлийн 5, 6 дугаар бүлгээс тодорхой үзэж болно¹.

Ер нь “Энэтхэг, Түвд, Нанхиадын соёлын нөлөөнд орсон үедээ тэдгээрийн эрдэнэсийн сангаас өөртөө зохимжтой, хэрэгтэйг нь Монголын утга зохиол биедээ шингээн авч байлаа. Мөн эдгээр орны шашны бурангуй соёлын балар мананд оровч Монголын уран зохиол үндэснийхээ онцлогийг хадгалан монгол зүсээр нь авч гарч чадсан юм аа... Ийнхүү монгол уран зохиол үндэсний болон нийт хүн

¹ Дамдинсүрэн, Ц., ба Цэнд, Д. (ред.). (1977). *Монголын уран зохиолын тойм: Хоёрдугаар дэвтэр (XVII–XVIII зууны үе)*. ШУА.

төрөлхтний шинж чанарыг шилдэг бүтээлүүддээ хадгалж иржээ” (Түдэв, 1975:276-277) хэмээснийг энд мөн хамаатуулан дурдах нь зүйтэй хэмээн үзлээ.

Орос, Монгол, Хятад хөрш гурван улсын түүх, нийгэм-эдийн засаг, соёлын болон утга зохиолын харилцаа холбооны талаар өгүүлэхдээ утга зохиол судлаач, доктор С.Байгалсайхан “Түүхийн энэ он цагийн соёл, утга зохиолын харилцаа холбооны нэг гол тод жишээ бол М.Шолоховын “Дөлгөөн Дон”, Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир”, Бүрэнтөгсийн “Дэлгэрхангай” зохиолууд болно. Дэлхийн нэгдүгээр дайны дараахан Орос оронд өрнөсөн Октябрийн хувьсгал, тэр хувьсгал Доны казакуудын овог хувь хүмүүст хэрхэн туссан, түүнийг хэрхэн хүлээн авсан түүхийн ээдрээтэй нэгэн хэсгийг “Дөлгөөн Дон” романд үзүүлсэн бол Монголын зохиолч Ч.Лодойдамба тэрхүү романыг ширээний ном болгон жишээ авч “Тунгалаг Тамир” романаа бичсэнээ дурссан нь бий. Гэвч энэ нь өөр улс үндэстний утга зохиолын зүйлийг дуурайн хуулбарласан хэрэг биш, түүнтэй адилаар өөрийн үндэстний түүхийг идээшүүлэн үзүүлсэн ХХ зууны Монголын гайхамшигт зохиол болж чадсан юм... Тэгвэл энэхүү “Тунгалаг Тамир” романы нөлөө Өвөр Монголын зохиолч Бүрэнтөгсийн “Дэлгэрхангай” романд туссан байна” (2020:216) хэмээн онцлон тэмдэглэсэн нь буй. Энэ мэтээр “1941 оны эцсээр Э.Оюун зөвлөлтийн зохиолч Вольскийн “Дудка” зохиолоос санаа авч үлгэрийн сэдвээр “Гайхамшигт лимбэ” жүжгийн зохиол бичжээ” (Жамсранжав, 1985:161) гэх мэтийн ажиглалт дүгнэлт, баримт жишээг уран зохиол судлаач, шүүмжлэгчдийн бүтээлээс² хялбархан олж болно.

Монгол болон өрнө, дорнын улс орнуудын уран зохиолын гадаад харилцаа холбооны үндсэн дээр хувилбар зохиол үүсэн бүрэлдэхээс гадна монгол ба монгол туургатан ард түмнүүдийн уран зохиолын дотоод харилцаа холбоон дээр үндэслэн бас хувилбар зохиол үүсэн бүрэлддэг байна. Үүний жишээнд Жангарын туулийн олон хувилбарыг хамаатуулж болно. Энэ тухай аман зохиол судлаач У.Загдсүрэн “Монгол, халимаг “Жангар” нь угтаа нэгэн эх сурвалж бүхий боловч хожим тус тусдаа өрнөн хөгжсөн өвөрмөц ялгаа бүхий хувилбарууд юм” (Загдсүрэн, 1977:236) гэсэн нь бидний энд өгүүлэн буй зүйлийн нэгэн тодорхой баталгаа болж байна.

Тэрчлэн “Дундад Ази, Түрэг, Кавказ, Румын оронд ихээхэн тархсан Насредины шог ярианд тогоо жалавч төрүүлсэн тухай өгүүлэмж мөн гарч байгаа нь монгол ардын шог хошин ярианы гадаад харилцаа холбоог харуулах нэгэн тодорхой баримт юм. Үүнийг дараах жишээгээр үзүүлье.

² “Уран бүтээлийн нөлөө, харилцааны тухай хэлэлцэхдээ үндэсний утга зохиолын тухай асуудлаас үүсгэж, түүнд үзүүлсэн нөлөөний дэвшилтэт, харгис шинжийг тодруулдаг билээ” (Цэдэв, 1973:9). “... Та сайхан сэдэв сонгож авсан байна. Уран зохиолын харилцаа, холбоо хоорондоо нөлөөлөх нь хэзээ ч чухалд тооцогдож байдаг юм. Энэ асуудлуудыг судлахад маш их өргөн хүрээний материал тулгарна гэж энэ талаар таны дурдсан ч зөв. Цаг цагийн нь материалуудыг өөрийн болгож, түүний тухай бодож дүгнэж цэгнэсэн байх ёстой болох байх аа. Одоохондоо ямар нэгэн тодорхой тодорхой асуудлыг авч эхлэх нь дээр. Тухайлбал, Зөвлөлтийн ямар нэгэн зохиолчийг аваад Монголын зохиолчдын бүтээлд яаж нөлөөлснийг судлах хэрэгтэй юм... Цэдэнжав нэг үе Маяковскийн яруу найргийг сонирхон оролддог байсан гэж бодогддог... С.Эрдэнэ болохоор Николай Островскийг өөрийнхөө тахин шүтэх хүн байсан хэмээн хэлж байсан удаатай... Ч.Лодойдамбыг болохоор Шолоховыг дуурайдаг гэж зэмлэж ч байлаа... Нөлөөлөх, дуурайх хоёр өөр зүйлэнд байгаа бололтой. Энэ бүгдийн учир начрыг олох нь сонирхолтой л хэрэг. Хуулбарлан дуурайсныг ажиглаад ялгаад авахад маш хялбар, харин нөлөөллийг тогтоох ер нь маш хүнд” (Михайлов, 1978.11.19). (Михайлов, 2007:66-67). “Бид Миеэгомбоос урлахын ухааныг суралцах хэрэгтэй юм. Түүний аяс өнгийг сохроор хуулбарлана гэсэн үг биш” (Цэнджав, 2007:130).

Монгол хувилбар

Бэлэн Сэнгэ нэг харамч айлаас том тогоог нь гуйж аваад махаа чанаж дуусаагүй байтал тогоогоо авчруулахаар зарцаа явуулахад баяны хонин тогоо манайд ирээд жалавч төрүүлж гаргалаа гэж хэлээд (хамт) өгөхөд...дуугүй л авчээ. (Гаадамба, Цэрэнсодном 1978, 196-р тал).

Азербайджанд тархсан хувилбар

Молла хөршөөсөө нэг том тогоо авч хэд хоногийн дараа дотор нь жижиг тогоо хийгээд эзэнд нь эргүүлэн өгчээ. Хөрш нь:

-Би чамд нэг л тогоо өгсөн шүү дээ гэхэд Молла:

-Чи их азтай хүн юм, энэ шөнө тогоо чинь төрсөн гэжээ. (Тахмасиг 1975, стр 274, 276)” (Сампилдэндэв, 2001:11).

Мөн “Сулхарнайн тууж” ч гэсэн судлаачдын таамаглалаар “орчуулгын зохиол” байж мэдэх ч яах аргагүй нүүдэлчдийн уран сэтгэлгээний хэв шинж, мөн чанарыг хадгалж байдаг” (Батхуяг, 2021:111). “... “Сулхарнайн тууж” бол Македоны Александрын тухай зохиолын монгол хувилбар гэдэг үзэл их тархсан байдаг. Да багш, Д.Цэрэнсодном нар ч энэ л шугамыг баримталдаг. Харин Да багш “Александр хааныг тийм урт наслав гэдэг домог миний уншсан зохиолуудад тааралдсангүй” хэмээн зориуд онцолж тэмдэглэсэн нь зарим талаар “Сулхарнайн тууж” бол Александрын домогтой холбоотой биш гэдэг санааг тойруугаар агуулж буй мэт санагдмуй. “Сулхарнайн тууж” гэдэг нэрийг Да багш өгсөн бөгөөд олдсон бичвэр нь нэргүй ажээ” (Лочин, 2019:331).

Монголын уран зохиолын гадаад харилцаа холбооны талаар³ манай орны үе үеийн уран зохиол судлаач, ахмад эрдэмтэд хангалттай судлан онол-арга зүй, судалгаа шинжилгээний арвин их туршлага, мэдлэг хуримтлуулсан нь уран зохиолын гадаад харилцаа холбооны асуудлын зэрэгцээ бас дотоод харилцаа холбоо гэсэн ойлголт байж болох юм гэж үзэхэд хүргэсэн билээ. Ер нь уран зохиолын харилцаа холбоо гэхээр хамгийн цөөндөө хоёр уран зохиол хамаарах бөгөөд аль нэг зохиолыг нь унших юм уу сонсонгуут өөр нэг зохиол шууд сэрэгдэн санагдах ийм нэг байдлыг л уран зохиолын дотоод харилцаа холбоо гэсэн утгаар, нэг бодлын ихээхэн бүдүүвчлэн ойлгож байна. Тухайлбал “Мартъя” гэдэг дууг сонсонгуут “Мартахгүй” гэдэг дуу санаанд орох ч юм уу, аль эсвэл “Шинэ цагийн хуучин хүү” гэсэн өгүүллэгийг уншингуут Д.Нацагдоржийн “Хуучин хүү” өгүүллэг бодогдох ч юм уу, ийм л нэг жишиг жишээний зүйл хэмээн ойлгож болно.


Ер нь “Уламжлалт арга, үзэл бодол, онолын байгууламжаар дамжуулж ертөнцийг /амьдралыг/ тайлбарлах, дүрслэх боломж туйлын явцуу болж байгаа бөгөөд чухам ийм ч учраас орчин цагт утга зохиолын дүр төрх үндсээрээ өөрчлөгдөх зайлшгүй шаардлагатай болж байна гэж өнөөгийн постмодернистууд үзэж байна. Үүний нэгэн тод жишээ нь английн зохиолч эмэгтэй, утга зохиол судлаач Кр.Брук-Роуз /Chr. Brooke-Rose/-ын “Ишлэлийн сэтгэхүй” хэмээх ойлголт, нэр томъёо юм. Энэ ойлголтыг анх постструктуралистууд гаргаж ирсэн бөгөөд энэ нэр томъёог хэрэглэх болсон шалтгааныг тайлбарлахдаа: бодгаль хүний зохиол бол соёлын сүлжээн дотор бүтдэг нэгэн төрөл зангилаа мөн. Тийм зохиол утгаа ямагт хамтын

³ Энэхүү асуудалд холбогдуулан дараах бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү. Үүнд: Г.Галбаяр (2006, 2010, 2020), С.Дулам (1976, 1977), С.Лочин (1973; 2019; 2024), С.Хөвсгөл, Д.Ариунчимэг (1998), Л.Хүрэлбаатар (1989). Тэрчлэн “Монголын аман болон бичгийн зохиол хийгээд шинэ үеийн яруу найргийн харилцаа холбоо, уламжлан хөгжсөн түүхэн явцыг ганц сэдэвт зохиолын тэргүүн, дэд бүлэгт хэд хэдэн үндсэн асуудлаар авч үзсэн” (Цэдэв 1973:145)-ийг мөн бүтээлээс нь дэлгэрүүлэн үзнэ үү.

бүтээл байдаг. Өөрөөр хэлбэл аливаа зохиол бол абсолют утгаараа зөвхөн ганцхан тухайн зохиолчийн “цэвэр” өөрийнх нь хувийн бүтээл хэрхэвч биш олон зууны түүхэн уламжлал, соёлын дам нөлөө, нэг ёсондоо бусад үй түмэн бүтээлүүдээс шууд ба шууд бус ямар нэгэн хэлбэрээр “хуулбарласан” ишлэл бүтээл мөн гэж үзсэн ажээ” (Энхбаяр, 2019:77-78).

Бид сүүлийн үед орчин цагийн монгол хэлний уран сайхны эхийн нэн өвөрмөц хэв шинжийн баримт хэрэглэгдэхүүн бүртгэн зарим нэг ажиглалт туршилт хийж эхэлж байгаа бөгөөд энэ хүрээндээ цуглуулсан⁴ Монголын уран зохиолын гадаад, дотоод харилцаа холбоо гэдэгт хамааруулж болохуйц хэмээн үзсэн зохиол бүтээлүүдийг дараах байдлаар ангилан ялгаж үзэх саналтай байна. Үүнд:

⁴ Монгол хэлний уран сайхны эхийн хэлбэр, бүтэц, зохиомж, агуулга, өгүүлэмжийн талаар тусгайлан ажиглах зорилгоор бид эхний удаа 2022 онд Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 3-р салбарын 84.35 мо:А-Я, 84/5мон/-5:А-Я гэсэн шифр бүхий яруу найраг, хүүрнэл буюу үргэлжилсэн үгийн бүх зохиол, тэрчлэн уран зохиолын төрөл бүрийн түүвэр, эмхэтгэл, дээж бичиг зэрэг нийтдээ 2000 гаруй номыг шүүрдэн үзэж энэ зуур хэд хэдэн илтгэл хэлэлцүүлэн хэвлүүлэв. Үүний дараа 2025 оноос эл номын сангийн төв байран дахь чөлөөт уншлагын А танхимын 84 (5 мон)-5 гэх шифр бүхий Монголын яруу найраг, шүлгийн зохиолын төрөл зүйлийг А-гаас Я үсэг хүртэл нь мөн нэгбүрчлэн шүүрдэн үзлээ. Ийнхүү Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн нэг танхим болон ганцхан салбарт байгаа уран зохиолын номын сан хөмрөгөөс захиалан үзэж, гүймэгхэн түүвэрлэхэд л олон жишээ баримт бүртгэгдсэн бөгөөд цааш нь бусад номын сангаас гүнзгийрүүлэн хайвал мөн ч их арвин хэрэглэгдэхүүн олдох боломжтой нь мэдээж бөгөөд ингэвээс ихээхэн цаг хугацаа зарцуулах шаардлагатай болох юм байна. Иймд холбогдох жишээ баримт эрж хайх, түүж түүвэрлэх ажлаа түр зогсоож “олзыг олуулаа” гэгчийн жишгээр одоог хүртэл бүртгэн цуглуулсан жишээ баримтаа эмхлэн цэгцэлж, уул уран сайхны эхийн хэлбэр, бүтэц, зохиомж, агуулга, өгүүлэмж зэрэгт үндэслэн Монголын орчин үеийн уран зохиолын дотоод харилцаа холбооны талаарх энэхүү бүдүүвчилсэн ангиллыг урьдчилсан байдлаар хийхийг оролдов. Цаашид энэ чиглэлээр холбогдох баримт хэрэглэгдэхүүн түүвэрлэн нэмж олохын хэрээр өөр шинэ хэв маягийн зохиол бүтээл бүртгэгдэх боломжтой тул аливаа эрэл хайгуул, анхдагч судалгааны зүй ёсны хөгжил дэвшлийн дагуу энэ удаагийн урьдчилан гаргасан ангилал маань цаашдаа хэсэгчлэн, эсвэл бүр үндсээрээ ч өөрчлөгдөж болохыг судлаачийн хувиар үгүйсгэхгүй байна.



Монголын уран зохиолын харилцаа холбоог ийнхүү ерөнхийд нь гадаад ба дотоод харилцаа холбоо хэмээн ангилж, дотор нь бас өрнө ба дорнын уран зохиолын харилцаа холбоо гэж ялгахын зэрэгцээ Монголын уран зохиолын дотоод харилцаа холбоог мөн хамгийн ерөнхий байдлаар далд ба ил харилцаа холбоо хэмээн ангилж болно.

Уран зохиолын далд харилцаа холбоо гэдэг нь тухайн хоёр ба хэд хэдэн зохиол нь агуулга, өгүүлэмж, үйл явдлын хувьд ямар нэгэн холбоотой байж болох тийм шинж байдлыг агуулсан байна. Энэхүү далд харилцаа холбоот зохиолыг цааш нь нэг зохиолд холбогдох хэд хэдэн зохиогчийн зохиол уу аль эсвэл нэг зохиогчийн

хэд хэдэн зохиол уу гэдгээр нь шалгавар болгож харилцаат ба холбоо(т) зохиол хэмээн ялгаж болно.

Нэгэн тодорхой зохиолд холбогдсон, өөрөөр хэлбэл, аль нэг зохиолд хариу болгосон шинжтэй, бусад зохиолчийн өөр зохиолыг өмнө нь анх хэвлэгдсэн зохиолтой нь нэгэн ерөнхий хэв шинж, нэгдсэн тогтолцоонд оруулж логик холбоогоор нь хамтатган харилцаат зохиол гэж нэрлэж байна. Ийм хэв маягийн дөчөөд зохиолыг бид бүртгэн цуглуулсан бөгөөд үүний жишээ болгож дараах зохиолуудыг төлөөлүүлэн дурдаж байна. Үүнд:

Д.Пүрэвдорж. Сэгс Цагаан Богд (Тэмээчин бүсгүйн захидал) (1969)

Т.Очирхүү. Улаанбаатар баяртай (Д.Пүрэвдоржийн “Сэгс Цагаан Богд” найраглалын баатар тэмээчин бүсгүйн захидлын хариу найраглал) (1971)

Ш.Дулмаа. Хүүгийн эцэгт бичсэн захидал (1971)

Р.Чойном. Хүүгийн ээжид бөхийж хэлэх үгс (Ш.Дулмаагийн шүлгэнд хариу

болгож бичих нь) (1972)

Ж.Баасан. Хүүгийн эхэд бичсэн захидал (Ш.Дулмаагийн “Хүүгийн эцэгт бичсэн захидлын” хариу) (1975)

Энэхүү харилцаат зохиолын талаар зохиогчийн урьд өмнө бичсэн, дор дурдсан бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү⁵.

Тухайн нэг зохиолчийн бүтээлүүд нь агуулга, өгүүлэмж, гол баатар зэргээрээ өөр хоорондоо холбогдсон шинжтэй байж болох бөгөөд үүнийг бид холбоо(т) зохиол гэж нэрлэлээ. Яагаад ингэж нэрлэж байна вэ гэвэл, нэг зохиогчийн бичсэн хоёр болон хэд хэдэн зохиол нь баатрууд, үйл явдал, дүрслэгдэхүүн, хөндсөн асуудал зэргээрээ өөр хоорондоо холбоотой, ямар нэгэн тодорхой гадаад болон дотоод шүтэлцээт харьцаатай байна гэж үзлээ. Бид холбоот буюу холбоо зохиолын гуч гаруй жишээ баримт бүртгэн цуглуулсан бөгөөд тэдгээрээс холбоо өгүүллэг: С.Эрдэнийн “Хулан бид хоёр” (1960), “Хулан Цамба хоёр” (1965), “Хулан бид хоёр гучин жилийн дараа” (1995), холбоо тууж: Б.Баастын “Хангайн Бор” (1970), “Хөвчийн Бор” (1974), “Элдэв учрал” (1976-1977), “Хадхүү, Батхүү хоёр” (1983), “Хадхүүгийн өдрийн тэмдэглэл буюу хөдөөд болсон номын баяр” (2002); С.Эрдэнийн “Холбоо гурван тууж” буюу “Хөх хулгана жил” (1970), “Сэмжүүдэй” (1967), “Хүүхнүүдийн зун” (1978), холбоо роман: Ж.Бямбын “Хорвоогийн өнгө” (1970), “Энэрэлгүй хорвоо” (1980), “Үнэний хорвоо” (1984) зэргийг төлөөлүүлэн дурдаж болно. Тэрчлэн холбоо шүлэг, холбоо найраглал, бүр холбоо найруулал ч байж болох ажээ. Тухайлбал, “Д.Цэвэгмид 1941 онд “Миний баялаг” шүлгээ бичсэн байна. Үүнийг 1940 онд түүний бичсэн “Аялах замд” шүлгийн үргэлжлэл гэлтэй” (Жамсранжав, 1985:16) гэсэн нь угтаа холбоо зохиолд хамаарч болох юм. Энэхүү холбоо зохиолтой холбогдуулан зохиогчийн өмнө хийсэн зарим ажиглалт, туршилтыг дор дурдсан бүтээлээс нь үзнэ үү⁶.

⁵ Мөнх-Амгалан, Ю. (2019). Монголын орчин үеийн харилцаат яруу найргийн тухай асуудалд. Орхон Их Сургуулийн эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл; Мөнх-Амгалан, Ю. (2019). Монголын орчин үеийн харилцаат яруу найргийн тухай асуудалд. Монгол судлал. 42 (506). 100-109; Мөнх-Амгалан, Ю. (эмх.). (2020). Монголын орчин үеийн харилцаат яруу найраг. Хянан тохиолдуулсан Д.Галбаатар, С.Алтантуяа. Улаанбаатар: “Соёмбо принтинг” ХХК. 180.

⁶ Мөнх-Амгалан, Ю. (2024). Монголын орчин үеийн холбоо зохиолын тухай асуудалд. Орхон Их Сургуулийн эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл; Мөнх-Амгалан, Ю. (2024). Монголын орчин үеийн холбоо зохиолын тухай асуудалд. Эрдэм шинжилгээний бичиг. *Орхон Их Сургууль*. 24, 33-56; Мөнх-Амгалан, Ю., Алтантуяа, Ч. (2025). (эмх.). *Монголын орчин үеийн холбоо зохиол*. Анхдугаар хэвлэл. (Сургалт, судалгаанд зориулав). Галбаяр, Г. (ред.). Улаанбаатар (хэвлэлд).

Тэрчлэн нэг зохиолчийн зарим зохиол өөр хоорондоо холбоо(т) зохиолын харилцаа үүсгэдгийн нэг адил мөн нэг зохиолчийн зохиолууд өвөр зуураа хувилбар зохиолын харилцаатай байж болох бөгөөд үүнийг судлаачид хувилбарт зохиол, хувилбар шүлэг гэх зэргээр нэрлэсэн байна⁷.

Уран зохиолын ил харилцаа холбоо гэдэг нь тухайн нэг зохиол өөр аль нэг зохиолтой ямар нэг байдлаар холбоо хамааралтай нь илтэд мэдэгдэх тийм зохиолуудын хүрээнд яригдах ойлголт юм. Энэхүү ил харилцаа холбоог цааш нь дуураймал ба хуулбар зохиол хэмээн хамгийн ерөнхий байдлаар ялган үзэж болно.

Дуураймал зохиол гэдэг нь урьд өмнө хэн нэгэн хүний зохиосон уран сайхны бүтээлийг зориуд дуурайн түүнээс янз бүрийн байдлаар үлгэр авч уламжлал⁸ шинэчлэлийн зааг дээр туурвисан бүтээл бөгөөд бид одоогоор ийм хэв маягийн гучаад зохиол цуглуулаад байна. Эдгээрээс дараах хоёр хос бүтээлийг төлөөлүүлж жишээ болгон үзүүлье. Үүнд:

⁷ Энэ талаар Д.Нацагдоржийн 16 зохиолын 18 хувилбарыг бүртгэж хэл судлаач, багш Б.Пүрэв-Очир бичихдээ "...Нацагдоржид олон хувилбартай зохиол хэд хэд байна... Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд хадгалагдаж буй Д.Нацагдоржийн зохиолын гар бичмэл эхүүд, удаа дараагийн (1945-2006) **“Зохиолын түүврүүд”** болон эх бичвэрийн судалгаанууд, тайлбар сэлтийг үзэхэд их зохиолчийн зарим зохиол нь хувилбартай болсон хэд хэдэн шалтгаан байна гэж үзэв. **1.** Их бичгийн хүн Нацагдорж маань зохиол бүтээлээ туурвихдаа нэг сэдвийг үргэлжилсэн (хүүрнэл) ба шүлэглэсэн (яруу найраг) гэсэн хоёр хэлбэрээр бичдэг тийм авьяас билэгтэн байсан. Үүнээс шалтгаалж, хэд хэдэн зохиолд нь хувилбарууд үүсэн нь харагдаж буй... **2.** Д.Нацагдорж, нэг сэдэл-үүтгэл санаа, нэг сэдвийг 2-3 хувилбараар бичиж, сонирхолтой цохолбор хийдэг, дахин давтан найруулж туршдаг байснаас хувилбарт зохиолууд гарсан байна... **3.** 1945-1996 оны хооронд хэвлэгдсэн Д.Нацагдоржийн **“Зохиолын түүврүүд”**-ийг хэвлэлд бэлтгэхдээ гар бичмэлтэй сайтар нягтлан тулгаагүй, гар бичмэлийг буруу ташаа уншсан, зарим зохиолын үг, өгүүлбэр, хэл найруулгыг өөрчлөн засварлаж буулгасан, эх бичвэрийн судалгаа хийсэн хүмүүс өөр өөрөөр ухаарч, нэмж хассан, тухайн цаг үеийн үзэл сурталд нийцүүлэхийг оролдсон, уг зохиолын үүтгэл санааг ойлгоогүйгээс агуулгад өөрчлөлт оруулсан, зохиолын нэрийг өөрчилсөн зэргээс үүдэж, алдаа мадагтай болж, хувилбарууд ч гарчээ” (2013:119-121) хэмээн онцлон тэмдэглэсэн байна. Тэрчлэн утга зохиол судлаачид "... **4.** С.Буяннэмэхийн шүлэгт нэг сэдвийг дахин хуулсан, ахин засаж өөрчилсөн, мөр бадаг зөрөөтэй шүлэг олон байна. Иймд түүний бүх шүлгийг төгс сайны жишээнд авч үзэх боломжгүй. Тэгвэл түүний шүлгийн туурвилын шинжилгээнд ташаа зүйл гарч болох юм. Тухайлбал, Интернационалын дуу гэхэд 4, Намын тухай гэхэд 3 янзын жаахан зөрөө бүхий хувилбар шүлэг олон байна” (Сумъяа, Болормаа, 2015:204) гэж дүгнэсэн зүйл буй.

⁸ “Уламжлал нь урьд үеийн зохиолчид болон зохиол бүтээлийн аль нэг талыг механикаар давтана гэсэн үг биш, харин өмнөх үеийн утга зохиолын баялаг өв сангаас бүтээлчээр суралцах, санаа авах үйл явц юм... Хүн бүхний мэдэх А.С.Пушкины **“Хүний гараар босоогүй хөшөө дурсгалаа босгов, би”** гэж эхэлдэг алдарт **“Памятник”** шүлэг нь түүний өөрийнх нь багш Н.Державины **“Памятник”** шүлэгтэй туйлын адил буюу санаа авсан байдаг бол Н.Державины энэ бүтээл нь эртний Ромын их яруу найрагч Горацийн **“Памятник”** шүлэгтэй хүйн холбоотой буюу уламжлал шинэчлэлийн сүлжээнд оршдог болохыг судлаачид санал нэгтэй тэмдэглэсэн байдаг” (Энхбаяр, 2019:136-137) гэсэн онолын гаргалгааг бид энд онцлон тэмдэглэж баримталсан болно. “Гэтэл манай яруу найрагчдын дотор өөрийн гэсэн дуу хоолой, өвөрмөц урлаггүй өмнө гарсан аятайхан шүлгийн бэлэн жорыг хэвээр ашиглан нэгэн хэвээр цутгаж, бие биеэ дуурайсан хуулбар шүлэг бичих явдал арилаагүй байна. Нэг үе манай яруу найрагчдын бүтээлд В.Маяковскийн уламжлал зарчмыг баримталж буй гэдэг нэрийн дор түүний шүлэг зохиолын мөрийг шатлан бичих гадаад хэлбэрийг хөнгөнөөр дуурайж (Ц.Цэдэнжав, Ц.Гайтав, Ц.Багцэвэл) өөрийгөө хуурах явдал гарч байсан бол 60-аад оны үед С.Есенины оросын тосгоны уянга найргийг дуурайж Монголын хөдөө нутгийн **“уянга дуулал”** бүтээх гэсэн гэнэн дуурайлт залуу яруу найрагчдын дунд ихэд дэлгэрч байсан билээ. Эдний аль нь ч гэсэн яруу найрагт бүтээлч уянга болж чадаагүй нь манай яруу найрагчид их бүтээлчдээс суралцахыг дуурайхаар сольсон гэнэн ойлголттой холбоотой ажээ” (Цэнд, 1972:252).

Самьяа ноён (Домогт харилцаа дуунаас)

3. Ламьяа лам, Жууяар хүүхэн хоёрын дуунаас:

-Дурдан гэмээнэ дурдан юмсан даа

Дундаа дугуй хээтэй бажгир дурдан юм шүү дээ хө

Дур болоод сэтгэл чинь Самьяа ноён дээр ойчсон бол хө

Дурдан юугий минь эргүүлж өгнө үү Жууяар минь дээ хө

-Дурдан өгөхийнхөө үедээ Ламьяа минь ээ хө

Дур болоод сэтгэлд минь унаж байгаад өгсөн биз дээ хө

Дурдангийнхаа хойноос гунихарч гомдоод байвал даа хө

Духаа цоортол мөргөж байгаад аваарай даа хө

-Бэлзэг гэмээнэ бэлзэг юмсан даа

Бээжинд тунгаасан биндэрьяатай шижир алт юм шүү дээ

Бие болоод сэтгэл чинь Самьяа ноён дээр ойчсон бол хө

Бэлзэг юугий минь эргүүлж өгнө үү Жууяар минь дээ хө

-Бэлзэг өгөхийнхөө үедээ Ламьяа минь ээ хө

Бие болоод сэтгэлд минь унаж байгаад өгсөн биз дээ хө

Бэлзэгнийхээ хойноос гунихарч гомдоод байвал даа хө

Байшингийн үүдэнд гурав мөргөөд аваарай даа хө

Эх сурвалж: Гун-Аажав, Т. (эмх.). (2008). *Монгол ардын дуу*. Дэд дэвтэр. Ардын богино дуу. Оюунбат, Р. (ред.). Улаанбаатар: 106.

И.Агваандаш. Архичин, архи хоёрын харилцаа дуу (*Ардын дууны маягаар*)

- Зүрх гэмээ нь зүрх юм даа хө

Зүүн талын цээжинд минь

Цохилж ирсэн зүрх шүү дээ хө

Зүүд болоод нойронд минь

Зүү тэвнээр хатгаад байвал та

Зүрх юугий минь эргүүлж өгнө үү, архи минь дээ хө

- Зүв зүгээр байтал минь

Зүтгэн шунан залгилахдаа та

Зүүд болоод нойроо

Хасаж байгаад уусан биз дээ хө

Зүрхнийхээ хойноос

Гунихарч гомдоод байвал та

Зүүгээр ч биш тонгоргоор

Зүсүүлж байгаад аваарай даа хө

- Тархи гэмээ нь тархи юм даа хө

Таван сайхан сэрлийг минь

Захирч ирсэн тархи шүү дээ хө

Санаа болоод ухааныг минь

Самууруулаад байвал та

Саруулхан тархийг минь эргүүлж өгнө үү, архи минь дээ хө

- Сав савандаа байтал минь

Саатан шунан залгилахдаа та

Санаа болоод ухаанаараа

Унаж байгаад уусан биз дээ хө

Тархиныхаа хойноос

Гунихарч гомдоод байвал та

Таталганы олсоор

Хүлүүлж байгаад аваарай даа хө.

- Цаг гэмээ нь цаг юм даа хө
 Цаашаа одвол наашаа ирдэггүй
 Цалин мөнгө л юм шүү дээ хө
 Ажил болоод амьдралыг минь
 Хамж цөлмөж дууссан болбол та
 Алдсанхан цагийг минь эргүүлж өгнө үү, архи минь дээ хө
- Цалин мөнгөө
 Дуусан дуустал залгилахдаа та
 Цаашаа болоод наашаагаа
 Бодоо нь үгүй уусан биз дээ хө
 Цагныхаа хойноос
 Гунихарч гомдоод байвал та
 Цас болоод мөсөн доогуур
 Шургаж байгаад аваарай даа хө.

Эх сурвалж: Агваандаш, И. (1989). Дөрвөн улирлын инээмсэглэл.
 Редактор П.Пүрэвсүрэн. Улаанбаатар, 28-29.

Д.Равжаа. Үлэмжийн чанар

Үлэмжийн чанар төгөлдөр
 Өнгө тунамал толь шиг
 Үзэсгэлэнт царайг чинь
 Үзвэл лагшин төгс маань
 Үнэхээр сэтгэлийг булаанам зээ
 Хөшүүн сэтгэлийг уяруулагч
 Хөхөө шувууны эгшиг шиг
 Хөөрхөн эелдэг үг чинь
 Хүүрнэн суухад урамтай
 Хөөрхөн аалыг мину зээ.
 Учирмагц сэнгэсэн
 Уран голшиг бие чинь
 Угаас хамт бүтсэн
 Улаан зандан үнэр шиг
 Улмаар сэтгэлийг хөдөлгөнө зээ
 Бадмын дундаас дэвэрсэн
 Балын амт адил
 Баясгалант ааль чинь
 Бахдаж ханашгүй
 Баярыг улам арвитгана зээ
 Хүний энэ насанд
 Хүссэн хэргээ бүтээгээд
 Хүсэлт тэнгэрийн эдлэл мэт
 Хөлгүй жаргалангийн далайд
 Хөвж хамт жаргая

Эх сурвалж: Равжаа, Д. (1992). Яруу найргийн цоморлиг.
 Эмхэтгэж хэвлэлд бэлтгэсэн доц. Цагаан, Д. (эмх.). Ёндон, Д. (ред.).
 Улаанбаатар, Соёмбо хэвлэлийн газар, 41-42.

Ц.Дамдинсүрэн. Ертөнцийн чимэг
(“Үлэмжийн чанарыг” дууриалган зохиов)

Үзэмжит өнгийн сайхан нүдний чимэг гэвэл:
Үүлгүй тэнгэрт мандсан алтан наран сайхан.
Үржилт дэлхийд ургасан алаг цэцэг сайхан.
Үргэлж хөдөлмөр хийсэн чийрэг бие сайхан.
Үнэнч янагийн царай нь тэр бүгдийн дээж.
Яруу дууны сайхан чихний чимэг гэвэл:
Ян ууланд донгодсон хөхөөн дуу сайхан.
Ятга хуурын хангинасан уран эгшиг сайхан.
Ямагт сэтгэлийг хөдөлгөсөн уянгын ая сайхан.
Янаг хонгорын дуу нь тэр бүгдийн дээж.
Сэнгэнэх үнэрийн сайхан анхилуур чимэг гэвэл:
Сэрүүн уулыг бүрхсэн зандны үнэр сайхан.
Сэлүүн талыг хучсан агийн үнэр сайхан.
Сэвүүн утааг тунаруулсан хүжийн үнэр сайхан.
Сэтгэлийн хайртын үнсэх нь тэр бүгдийн дээж.
Амсах амтны сайхан хэлний чимэг гэвэл:
Аяганы амсрыг бялхаасан айраг цагаа сайхан.
Ардын цэнгэлийг мялаасан архи сархад сайхан.
Амтны охийг багтаасан алим жимс сайхан.
Амраг хүүхний уруул нь тэр бүгдийн дээж.
Таалж хүрэлцэхэд зөөлхөн биеийн чимэг гэвэл:
Талиман жороо морийг унаж явахад зөөлхөн.
Тансаг торгон хувцсыг эдэлж явахад зөөлхөн.
Тахиа нугасны дэгдээхэйг илж үзэхэд зөөлхөн.
Тавилант янагийн таалах нь тэр бүгдийн дээж.
Дэлгэр жаргалын сайхан ертөнцийн чимэг гэвэл:
Дээр дорын ялгаагүй тэгш эрхтэй сайхан.
Дэлхий даяар амгалан эв найртай сайхан.
Дэгжиж хөгжихийн баталгаа бүтээх ажилтай сайхан.
Дэргэдэх ханийн зүтгэл нь тэр бүгдийн дээж.

1966

Эх сурвалж: Дамдинсүрэн, Ц. (1969). Түүвэр зохиол.
Цэдэв, Д. (эмх.). Улаанбаатар. 168-169.

Энэ хоёр шүлгийн талаарх тусгайлсан судалгааг дараах судлаачдын бүтээлээс дэлгэрүүлэн үзэж болно⁹.

⁹ Галбаяр, Г. (2009). Д. Равжаагийн “Үлэмжийн чанар”, Ц. Дамдинсүрэнгийн “Ертөнцийн чимэг” шүлгүүдийг харьцуулан үзэх нь. *Хүрэл тогоот-2009: Шилдэг шүлгийн эмхэтгэл* (53–58). Улаанбаатар; Пүрэв-Очир, Б. (2008). *Сайн үйлсийг бүтээж салаа замаар явсан эрдэмтэн-зохиолч*. Улаанбаатар. Жич: Идшинноров (Ичинноров) хэмээх бүсгүйд зориулж зохиолч М.Ядамсүрэнгийн зохиосон “Үзэсгэлэн гоо” хэмээх шүлэг нь Д.Равжаагийн “Үлэмжийн чанар” шүлгээс бүтээлч үлгэр дуурайлал авсан байж магадгүй шинжтэй юм. Энэ тухай дараах эх сурвалжаас лавлан үзнэ үү. Үүнд: Монгол уран зохиолын дээжис-108. Цаасан шувуу-II. (2007). 108-р боть. Улаанбаатар. 308.

Энд өгүүлж байгаа дуураймал зохиолын талаар зохиогчийн урьд өмнө бичсэн, дор дурдсан бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү¹⁰.

Дуураймал зохиолыг цааш нь а/ даган дуурайсан, б/ үлгэрлэн дуурайсан гэж ялгаж болох бөгөөд үүний эхнийх нь тооны, сүүлийнх нь чанарын учир холбогдолтой үйлдлийн үр дүнд бүтээгддэг байна.

Ер нь “... манай зохиолчдын дотор нэлээд ул мөртэй байдаг харилцан дуурайх, ханаран ижилсэх явдлын гэм уршиг...шүлэг зохиолд ямар нэгэн маягаар үзэгдэх вэ? гэхээс болгоомжлоход илүүц биш гэж үзэж байна” (С.Лувсанвандан 1973:352), “Дуурайн давтах, “өнгөлөн” хуулбарлах замаар жинхэнэ урлагийн бүтээлийг буй болгодоггүй... Тэрчлэн ухаалаг инээдмийн охь болсон алдарт Мянгуужингийн үлгэр, “Робинзон Крузо” зэрэг бүтээлүүдийг шинэ агуулга, шинэ хэлбэрээр баяжуулалгүй, зөвхөн дуурайн бичсэн олон зуун “зохиогч” амжилт олоогүйг утга зохиол урлагийн түүх мэдэх билээ” (Цэнд-Аюуш, 1975:10), “Хоосон дууриал буюу “Эпигонство” гэдэг нь /грек хэлний еρίγονοι – родившиеся после/ буюу дараа нь төрж гарсан хэмээх үгээс эхтэй бөгөөд энэ нь: “уламжлалт дүрийг бүтээлч бус байдлаар даган мөрдөх” /Литературный энциклопедический словарь. М., 1987. с.510/ буюу зарим тохиолдолд нэгдүгээр эгнээний зохиолчдыг давтах, эсвэл олон нийтэд нэгэнт алдаршсан тийм шилдэг сайн утга, өгүүлэгдэхүүн, сэдэв, үйл явдал зэргийг хооронд нь хольж хутган хувиргах, улиг болтол давтах явдал юм” (Энхбаяр, 2019:219) гэх зэргээр манай туршлагатай онолч, эрдэмтэн багш, утга зохиол судлаач, шүүмжлэгч нар анхааруулан тэмдэглэсэн нь бидэнд нэгийг хэлж, хоёрыг сануулж байгаа хэрэг бөгөөд энд өгүүлэн байгаа дуураймал болон хуулбар зохиолыг цаашид нарийвчилж задлан шинжлэхэд арга зүйн чухал гаргалга, онол үйлдлийн зохих баримжаа болох юм.

Хуулбар зохиол нь өмнө гарсан аль нэг зохиолыг хуулбарлан зохиомжилсон шинжтэй бөгөөд үүнийг мөн цааш нь шууд ба шууд бус хуулбарласан зохиол гэж ялгаж болно.

Шууд хуулбарласан зохиолыг дотор нь хуулбарлан найруулсан болон хуулбарлан өөрчилсөн хэмээн ангилж болно.

Нэгэн тодорхой зохиолын агуулга, утга санаа, үйл явдал, үйл хөдлөлийг шууд хадгалан чөлөөтэй найруулан зохиомжилсныг хуулбарлан найруулсан зохиол гэж үзлээ¹¹. Үүнд Галидасын “Үүлэн зардас” (Б.Ринчений орчуулга) болон зохиолч, яруу найрагч Ж.Түмэнбаярын “Үүлэн зардас”-ыг хамааруулж байгаа бөгөөд үүний жишээ болгож “Үүлэн зардас” зохиолын нэг орчуулга ба түүнээс хуулбарлан найруулсан хувилбар маягийн зохиолын зөвхөн эхний нэг бадаг болон төгсгөлийн үгийг тус тус зэрэгцүүлэн дор үзүүлье. Үүнд:

Үүлэн зардас (Б.Ринчений орчуулга)

Сэрэмж алдсан нэгэн ягшас, хилинт эзний бошог зарлигаар
Сүр жавхлангаа бууруулан, үзэсгэлэнт амрагаасаа жилээр хагацаад
Сэтгэлд тааламжит гүнжийн угаалд ариудсан мөрний ойр,
Сүүдэр төгөлдөр галбарварас модот Рамын уулнаа суун авай...

Хэмээсэн үүнийг хар усан бар жилийн намрын дунд сард
Хэдийвээр санскрит эхээс хараахан буулгаж эс чадавч,

¹⁰ Мөнх-Амгалан, Ю. (2022). Монголын уран зохиол дахь дуурайн зохиохуйн зарим асуудал. *Монгол судлалын цуврал лекц* (No. 1). Орхон их сургууль, Монгол хэл, соёл судлалын төв.

¹¹ Мөнх-Амгалан, Ю. (2026). Монголын орчин үеийн хуулбарлан найруулсан зохиолын тухай асуудалд. Эрдэм шинжилгээний илтгэл. Орхон их сургууль.

Аялгуу сайхан монгол хэлнээ англиас чадан ядан орчуулаад,
Андуу эндүүг уучлан засахыг өтгөс Ринчен өчмүү.
Эртний соёлт манай ард түмэн хэзээ дээр цагаас
Энэтхэг энэ зохиолчийн “Үүлэн зардасыг” сонирхож
Судар амаар үзэн хэлэлцсээр ирсэн түүхтэй тул,
Сул үггүй сайхнаар дахин найруулахын бэлэг болог!

Эх сурвалж: Галидаса. (1963). *Үүлэн зардас* (Б. Ринчен, орч.).
Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. 61-62.

Үүлэн зардас (Ж.Түмэнбаярын найруулсан хувилбар¹²)

1. Ариун дээд Шамбалын орны хүмүүн бус нэгэн ягшас
Алба үйлдээ ихэд осолдон Намсрай бурхны гэсгээлд унаж
Арга чадал, хувилгаан чанар, сүр жавхаа нь үгүй болж
Амраг эхнэрээсээ хагацан хөөгдөж, нэгэн жилээр алсад цөлөгдөж
Алдар цуут Жанага хааны сэтгэлд тааламжит гүнж
Алдрай биеэ угааснаар ариудсан домогт мөрний хөвөөнд
Алтлаг зандан галбарварас модны сэрүүн сайхан сүүдэртэй
Рамагийн ууланд үнсэнд хаягдсан шалз шиг суужээ...

Төгсгөл шүлэг

Хариас олдох ногоон мөнгө бурханы гэсгээлтэй яг адил
Хаа холын нүсэр хотууд Рамын уултай эгээ ижил
Хааяагүй байх үхлийн нян араатан мэт өршөөлгүй
Хар ажлын хоног хугацаа цөллөг мэт барагдашгүй
Халин нисэх залуу нас улиран улиран одно
Хайр янаглал дотно учрал улам улам холдоно
Хагацан салсан янаг хань ураг бүлээ санан гансравч
Хатуу заяат ядуу Монголдоо буцан ирэхийн аргагүй

Эртний Энэтхэгийн Гувира тэнгэрийн хилэнд өртөх мэт
Эрдэнэсийн эзэн Намсрай бурханы цаазанд унах мэт
Эд мөнгө илүүхэн олж амиа зогоох л гэхдээ
Эх орноосоо алсад одож хагацлын бэрхэд унасан
Эвийлэм охид, идэр хөвгүүдийн гунигт харцыг үзээд

¹² “Билгүүн номч Б.Ринчен гуай энэ найраглалыг англи хэлнээс өөрөө орчуулсан, Даанжуур сударт хэвлэгдсэн төвдөөс орчуулсан, гавж Эрдэнэпил гуайн мөн төвдөөс орчуулсан, Сагаржав гуай нанхиадаас орчуулсан дөрвөн хувилбарыг маш тодорхой тайлбарын хамт 1962 онд хэвлүүлсэн байна. Их дуун хөрвүүлэгч Ринчен гуайн орчуулга өөгүй төгс бүтээл юм. Гэхдээ өөрөө гэрээслэн бичихдээ “... энэ нэг зохиолыг гурван хэлнээс дөрвөн орчуулга хийснийг манай авьяас билигт яруу найрагч нар, дур сонирхол нь хөдөлж, зориг нь бадарвал монголоороо дахин бүр чадалтай сайхнаар найруулахад нь тус дөхөм болох асан бол уу гэж горьдон, тэгвэл хуучин монгол найруулагч нар, одоо төвд, хятад, англи гурваас хир хирээрээ орчуулсан Эрдэнэпэл, Сангаражав бид гуравын махарсан маань, оросын яруу найрагчид, европ хэлнээс Галидасын зохиолыг оросоор найруулсантай адил, монгол хэдэн орчуулгаас нийлүүлж нэг сайхан монгол найраглал болоход тус дөхөм болоосой гэж хүсэн горьдоно” гэсэн билээ. Тэдгээр өвгөд дээдсийнхээ гэрээслэлийг биелүүлэхийг оролдох нь тэднийг магтан бичсэн боть боть хоосон магтаалаас илүү тус буянтай үйл болох болуу гэж боддог болохоор, бас ч тийнхүү гэрээсэлсэн нь зайлшгүй шалтгаантай байсан биз хэмээн итгээд, авьяас билигт яруу найрагч нь биш боловч өөрийгөө голохгүйгээр арай ядан андуу эндүүтэй найруулан бичлээ... Энэ зохиолыг миний бие харь хэлнээс орчуулаагүй, өөрөө зохиогоогүй, монгол хэлээр байх олон орчуулгыг зэрэгцүүлэн шинээр найруулан бичсэн болохоор үг хэллэг нь давтагдсан, тэр байтугай шууд хуулбарлагдсан зүйл нэлээд бий” (Түмэнбаяр, 2011:99-100).

Элэг зүрх минь эмтрэн урагдах өвгөн би, чилж
Энхрий ханийн үнэнч сэтгэл, баг журмаа алдалгүй
Эргэн учрах болтугай хэмээн эвлүүлэн бичлээ. Үүнийг. 2007 он.

Эх сурвалж: Түмэнбаяр, Ж. (2011). *Нууц товчооны адуу*.
Шүлэг, найраглал, өгүүллэг, тууж. Улаанбаатар. 102.

Нэгэн тодорхой зохиолын үйл явдал, өгүүлэмж, үзэл санаа, агуулга зэргийг яг тэр чигээр нь хадгалан, харин хэлбэрийнх нь хувьд уран зохиолын болон урлагийн өөр төрөл зүйлээр илэрхийлэн зохиомжилсон зохиолыг хоёрдахь хэв маягт оруулж байна. Дараах хоёр хос зохиолыг үүний жишээ болгон дурдаж болно. Үүнд:

Л.Түдэв. Нүүдэл, суудал (Роман)

П.Бадарч. Нүүдлийн замд [1 бүлэгт, 3 үзэгдэлт дуурийн цомнол] (*Төрийн шагналт зохиолч Л.Түдэвийн “Нүүдэл, суудал” романы зарим бүлгээс сэдэвлэж энэ бэсрэг дуурийн цомнол бичлээ*)

Б.Догмид. Тууварчны охин (Өгүүллэг)

З.Түмэнжаргал. Тууварчны охин (*Найраглал. Б.Догмидод*)

Энд дурдсан өгүүллэгийн зөвхөн эхний цогцолборыг хэрхэн шүлэглэж, хуулбарлан өөрчилснийг үзүүлье. Үүнд:

Б.Догмид. Тууварчны охин (Өгүүллэг)

Би үдшийн цагаан гэгээ замхарч байхад адуугаа бэлчээрт залаад морио услахаар нуур руу дэргүүлэв. Намайг очиход өдөржин адуу малын хөлөөр шалигдан булингартан өтгөрсөн нуурын ус шингэрэн тунаад намрын цагаан шөнийн тэргэл саран доор хөвөө бүр дээрээ хөөс сагуулан хөнгөн долгис хаялан байх нь миний балчир ахуй цагт эмээ ээжийн ярьж өгдөг байсан үлгэрт гардаг: эгч дүү арван гурван дагинасын долоон өнгийн солонгоор бууж ирдэг эрдэнийн цэнхэр далайтай зүйрлэм байлаа.

...

Улаанбаатар. 1970 он.

Эх сурвалж: Догмид, Б. (1976). Цэнхэрлэн харагдана. Улаанбаатар. 1976. 78.

З.Түмэнжаргал. Тууварчны охин (Найраглал)

Б. Догмидод

Цагаан гэгээ замхрав.

Чанх дээр анхны од цэцэглэв.

Би адуугаа залчихаад

Билүүтийн нуур руу дэргүүлэв.

...Өдөржин малын хөлөөр шалигдаж

Өтгөрсөн ус тунана.

Хөвөө болгондоо

Хөөс хулжааж

Хөнгөн долгис хаялна.

Эмээ ижийн минь ярьсан

Үлгэр санагдана.

Эгч дүү арван гурван дагинас

Солонго хөлөглөн бууж ирдэг

Эрдэнийн
Цэнхэр далай нүдэнд ургана.
... 1984.

Эх сурвалж. Түмэнжаргал, 3. (1987). Бид. Сүрэнжав, Ш. (ред.). Улаанбаатар. 62.

Хуулбарлан өөрчилсөн зохиолыг цааш нь ямар төрөл зүйлээс ямар төрөл зүйл болгон өөрчилсэн гэдгээр нь шалгавар болгож уран зохиолын болон урлагийн төрөл зүйлээр хуулбарлан өөрчилсөн зохиол гэж ялгаж болно. Тухайлбал уран зургийн бүтээлийг уран зохиолын төрөл зүйлээр хувирган өөрчилсөн арваад бүтээл бүртгэгдсэнээс дор заримыг нь дурдъя. Үүнд:

Жаргалын найман морь (Зураг)
Д.Батбаяр. Жаргалын найман морь (Эсээ?)
Ш.Дулмаа. Жаргалын найман морь (Шүлэг)
Д.Амгалан. Өвлийн үдэш (Зотон тосон зураг, 1961 он)
А.Самбалхүндэв. Битүүний шөнө (Бүдэг зураг) (Зураач Д.Амгалангийн сэдвээр)

Энд өгүүлсэн зүйлд хамаарах бүтээлүүдээс дараах бүтээлийг төлөөлүүлэн сонирхуулья. Үүнд:



69. Д. Амгалан. Өвлийн үдэш. 1961
он. зотон тос.

Д.Амгалан. Өвлийн үдэш

Энэ зургийн талаар “... Хэдийгээр зургийн боловсролоор маруухан ч гэсэн энэ их зураачийн “Өвлийн үдэш” гэдэг цас орсон өвлийн орой үнэгэн малгай тавьж хурган нударгаа эргүүлсэн залуу хархүү улаан сэгсүүргэн дээлтэй урт гээгтэй охиныг гэрээс нь гаргаж ирээд дулаахан нудрагандаа жижигхэн гарыг нь бариад зогсож байгаа зураг их таалагддаг. Хоёр залуугийн цаана хом, бөх, толгой нь цасанд хучигдсан сайхан ат, хархүүгийн унаж ирсэн морины нуруун дээр улаан бүүрэгтэй монгол эмээл тодоос тод. Охины гэрийн тооноор гэрэл цацарч, яндангаар нь их утаа гарч байгаа нь ээж нь тогоогоо гаргаж, аавд нь дал дөрвөн өндөр гаргаж байна даа гэж санагдана. Гадаа шинийн тавны бүүдгэрхэн сарны гэрэл байна уу гэмээр.

Залуу эр зориг гаргаж нэг сайхан үг хэлэхэд цаадах нь цэвэр ичимтгий зангаар бишүүрхэн газар ширтэж зогсоно. Хархүү хайртай хүүхнээ үнсэж ч чадалгүй мориндоо мордоод айлын хотноос холдсон хойно дуу аялаад давхисан байх. Хархүү хэр холоос ирсэн бол, хүүхэн хайрт хүндээ юу гэж ам алдсан бол. Гэртээ ороод аав, ээждээ юу гэж “худал” хэлсэн бол. Тэр шөнө янз янзын сайхан бодолд умбаж, нойр нь хулжсан байх даа. Юуг зүүдэлж хоносон бол. “Өвлийн үдэш” зургийг би 1962 оноос хойш өдий болтол ингэж уншиж, хөөрөлдөж ирсэн дээ” (А.Лхагва 2009:19) хэмээн хийсвэрлэн сэтгэж бичсэн зүйл бий.

А.Самбалхүндэв. Битүүний шөнө (Бүдэг зураг).

(Зураач Д.Амгалангийн сэдвээр)

Шинийн хууч
Шөнийн харанхуйд
Хөдөө айлын
Гадаа хаяанд
Нас тэнцүү
Хос залуу:
- Би чамдаа ...
- Юу гэнэ ээ?
- Чи харин ...
- За боль доо гэж
Сулхан ярилцсаар
Холхон зогсохдоо
Хунгар жигнэж
Дороос даарсан ч
Хонгор хоёр
Ерөөс тоосонгүй!
Харин тэгэхэд
Хархүүгээс өмнө
Хүйтэн жавар
Хүүхнийг “хайрлаж”
Алиман хацры нь
Амтлаад авахад
Зайдуу зогссон
Залуу бүсгүй
Хайртай хүнийхээ
Ханхар цээжинд
Нүүрээ наагаад
“Өөрөө мэд” гэжээ.

*

*

*

Битүүний шөнө
Хөдөөний малчин
Янаг хос л
Зөнөг есийн
Хүйтэн жаврыг
Халуун уруулаар
Хайлган алдаж
Айлган явуулдгаас
Жаврын эрч

Харьдаг буюу?
Хаврын урь
Ирдэг буюу?

Эх сурвалж: Самбалхүндэв, А. (1969). Хангайн уянга.
Гайтав, Ц. (ред.). Улаанбаатар. 111-112.

Тэрчлэн энд өгүүлж байгаа зүйлийн яг урвуу тал буюу уран зохиолын төрөл зүйлийг уран зургийн төрөл зүйлээр хуулбарлан өөрчилсөн (Б.Явуухулан. Би хаана төрөө вэ? (шүлэг) → Ж.Дэмбэрэл. Уран сэтгэмжийн гогцоо¹³ (зураг), Д.Равжаа. Үлэмжийн чанар (шүлэг) → М.Уранбэрх. Үлэмжийн чанар - 1. Үлэмжийн чанар - 2.¹⁴ (зураг), мөн үүнээс гадна урлагийн хоёр өөр төрөл, тухайлбал хөгжмийн бүтээлийг уран зургийн төрөл зүйлээр хуулбарлан өөрчилсөн (Жишээлбэл Б.Шаравын “Сэрсэн тал” үндэсний их найрал хөгжимд зориулсан бүтээлийг уран бичлэгээр илэрхийлсэн бүтээл), хөгжмийн бүтээлийг уран зохиолын төрөл зүйлээр хувирган өөрчилсөн (Canon¹⁵ (хөгжим) → Б.Батзаяа. Canon (шүлэг), Rain¹⁶ (хөгжим) → Б.Батзаяа. Rain (шүлэг), Б.Дамдинсүрэн. Хэнтийн өндөр ууланд (хөгжим) → Д.Маам. Хэнтийн өндөр ууланд (шүлэг), уран зургийн бүтээлийг бүжгийн төрөл зүйлээр хувирган өөрчилсөн (Б.Шарав. “Монголын нэг өдөр” (уран зураг) → Г.Мишээл. “Монголын нэг өдөр” (контемпорари бүжиг)¹⁷ зэрэг олон бүтээл гарсан байна. Хуулбарлан өөрчилсөн зохиолын талаар дараах бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү¹⁸.

Энэ мэтчилэн зохиолч үг хэлээр, зураач өнгө дүрсээр, бүжигчин үйл хөдөлгөөнөөр, дуучин дуу хоолойгоор, барималчин хэлбэр дүрсээр тус тус утга санаа илэрхийлж, уран дүр бүтээдэг болохоор урлагийн бүх төрлийн бүтээлийг өөр хооронд нь хуулбарлан өөрчилсөн бүтээл байж болох ажээ¹⁹.

Шууд бус хуулбарласан зохиолыг цааш нь сэдэвлэсэн болон элэглэсэн зохиол гэж ялгаж болно.

Нэгэн тодорхой зохиолын сэдэв, өгүүлэмж, үйл явдал, дүр, дүрслэлээс санаа авч бүтээсэн зохиолыг сэдэвлэсэн зохиол гэж үзэж байна. Жишээлбэл:

Хятадын зохиолч Пү Сүн-лингийн “Эрт эдүгээгийн гайхамшигт үзэгдэл” романы “Зян Син-гэ (Жиан Шин-хэ) дахин алтан сувд цамцдаа учралдав” гэх 23 дугаар бүлэг

Д.Бодоо. Үйлийн чанарыг үлгэрлэсэн үзэмжит өгүүлэл. Шүрэн эрихийн бүлэг

¹³ Энэ тухай утга зохиол судлаач, доктор Я.Баатарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү.

¹⁴ Энэ зургийн талаар МУБИС-ийн багш Э.Батчимэгийн бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү.

¹⁵ Германы хөгжмийн зохиолч Иоганн Пахельбелийн аялгуу.

¹⁶ Японы хөгжмийн зохиолч Риючи Сакомотогийн аялгуу.

¹⁷ Энэ тухай дараах ярилцлагаас тодорхой үзнэ үү. Үүнд: Г.Мишээл. “Монголын нэг өдөр”-ийг контемпорари бүжгээр илэрхийлнэ. - Б.Нямдарьтай хийсэн ярилцлага. 2024.12.17.

¹⁸ Мөнх-Амгалан, Ю. (2025). Монголын орчин үеийн хуулбарлан өөрчилсөн зохиолын тухай асуудалд. Эрдэм шинжилгээний илтгэл. Орхон их сургууль; Мөнх-Амгалан, Ю. (2025). Монголын орчин үеийн хуулбарлан өөрчилсөн зохиолын тухай асуудалд. *Орхон их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг*, 25, 176–192.

¹⁹ “Бүжгийн урлаг маш гайхалтай, аугаа ертөнц... Учир нь бүжиг хүмүүст асар их соёл түгээж, эрч хүч бэлэглэдэг урлаг. Тэр ч байтугай өөрсдийн илэрхийлэхийг хүссэн санаа, тухайн үеийн мэдрэмжийг хөдөлгөөний гоо зүйгээр дамжуулан хүмүүст бодитоор хүргэдэг. Тийм ч учраас бүжгийн урлаг бол хөдөлдөг яруу найраг гэлцдэг байх. Ерөнхийдөө бүжиг бол хүний биеэс гардаг урлаг гэж хэлнэ. Яруу найрагч бол үгээрээ, дуучид хоолойгоороо бүтээлээ хүмүүст хүргэдэг. Харин бид тухайн мэдрэмжийг биеийн хөдөлгөөнөөрөө илэрхийлж хүмүүст хүргэдгээрээ онцлогтой” (2024: А 7). Ярилцсан У.Цэцэгсүрэн.

Орогсдын ерөөл²⁰

Ц.Дамдинсүрэн. Гологдсон хүүхэн (тууж)

Үйлийн гурван толгой (домоғ)

Д.Нацагдорж. Учиртай гурван толгой (жүжиг)²¹

Д.Нацагдорж. Од

Д.Төрбат. Од

Б.Ойдов. Айн Жалудын цавчилдаан (тууж)

А.Сүглэгмаа. Гивлүүрт могой (Зохиолч Б.Ойдовын
“Айн Жалудын цавчилдаан” туужийн дүрүүдээс сэдэвлэв)

Гэсэрийн тууж

Г.Сэр-Од. Буйдан баатар

Монгол ардын дуу “Дөмөн”

Г.Сэр-Од. Дөмөн

Иймэрхүү хэв маягийн зохиолын талаар утга зохиол судлаач Ц.Буянзаяа бичихдээ Д.Бодоогийн (1885-1922) “... Үйлийн үрийг үлгэрлэсэн үзэмжит өгүүлэл” нь Дундад зууны үеийн Хятадын сонгомол зохиолууд тэр тусмаа “Эрт, эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл” хэмээх зохиолоос сэдэвлэн бичиглэгдсэн зохиол хэмээгддэг. Энэ тухай Бодоо өгүүллийнхээ төгсгөлд:

“Угаас баялаг төрсөн Радна хэмээгчийн үлгэр энэ нь
Урьдын уламжлалт сувдан цамцаас төржээ”

хэмээн өгүүлсэн байдаг. Учир нь уг дурдагдсан “Эрт, эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл” хэмээх зохиолын нэгэн бүлэг нь “Жиан шин хэ алтан сувд цамцдаан учралдав” хэмээн нэрийдэгдсэн байдаг бөгөөд Бодоо “Үзэмжит өгүүлэл” уг бүлгээс санаа аван бичсэн бөгөөд илтэд дуурайсан хийгээд мөн ялгагдах онцлог бүхий байдлыг хослуулан бичиглэсэн тухай судлаачид оноон тогтоосон байдаг” (2013:363) гэсэн бол утга зохиол судлаач, доктор С.Байгалсайхан “... Их зохиолчийн өөрийнх нь хэлсэн жишээ дуурайл аван түүнээс дооргүй зохиол бичнэ гэж хэлсэн “Орогсодын ерөөл” зохиолыг “Гологдсон хүүхэн” туужтай харгалдуулан туурвилын зарим тайлбарыг хийхийг зорьсон болно. Нэгд: Зохиолын зохиомж, бүтцийн хувьд нөлөө авсан гэж хэлж болохоор байна... XX зууны эхэн үеийн Монголын утга зохиол нь хятадын утга зохиолтой холбоотой харилцан нөлөөлж байсны жишээ нь Бодоогийн “Үзэмжит өгүүлэл” бөгөөд БНХАУ-ын судлаач Хувьсгалт “Үзэмжит өгүүлэл”-ийг бусад зохиолтой харгалдуулан судлаад зөвхөн хүний нэр, газар усны нэрийг өөрчлөн монгол зохиол болгон бичсэнийг харуулсан бөгөөд энэхүү нөлөөллийн үйл явц цаашид улам гүнзгийрэн хөгжиж Ц.Дамдинсүрэн нэр усыг зээлдэн даган хуулбарлах биш санаа сэдэл авч зохиомж бүтцийн хувьд адил төсөөтэйгээр зохион монгол ахуйг бичсэн байна. Хоёрт: Өгүүлэмжийн хувьд

²⁰ “20-иод оны дундуур миний уншсан хуучин уран зохиолын нэг ном бол Шагж багшийн Өвөр Монголоос олж ирсэн “Орогсдын ерөөл” гэдэг ном, нэн онцгой юм. Энэ номын гол баатар нь феодал ангийн төлөө зүтгэж явсан залуу түшмэл байв. Би тэгэхлээр ардын ангийн төлөө зүтгэж явсан залуу эмэгтэйн тухай бичнэ. Тэгэхдээ уг зохиолын зохиомж нь “Орогсдын ерөөл”-өөс доргүй байна гэж “Гологдсон хүүхэн тууж”-аа бичиж эхэлсэн билээ” (Дашдорж, 1988:38). Энэхүү эшлэлийг С.Байгалсайханы өгүүлэл (2019:151)-ээс дам авав.

²¹ “Д.Нацагдоржийн “Учиртай гурван толгой” зохиол нь харц ардын хос залуугийн хайр сэтгэлийн гунигт нэгэн домог, шинэ цагийн эмгэнэлт жүжгийн эх үндэс болсон түүх юм” (Лувсанвандан, 1987:220).

“Орогсодын ерөөл”-д ... амьдралын мөнхийн үнэнийг үзүүлсэн нь Ц.Дамдинсүрэн зохиолчид гүн сэтгэгдэл төрүүлж “Тологдсон хүүхэн” туужаа бичих сэтгэл санааг бэлдэж өгсөн бололтой” (2019:154). (Энэ нь) “... цаашид ч бусад зохиолчдын бүтээлд уламжлан хөгжсөнийг Оросын нэрт монголч Л.К.Герасимович Д.Цэвэгмэдийн “Хоньчин Найдан” зохиолын байгууламжийн тухайд өгүүлэхдээ “Тологдсон хүүхэн” туужаас суралцсан талаар онцлон тэмдэглэсэн байдаг” (Байгалсайхан, 2020:214) хэмээн тодорхойлон дүгнэжээ.

Г.Сэр-Одын дээрх хоёр зохиолын талаар утга зохиол судлаач Д.Дашдорж “... 1935 онд Улсын төв цэнгэлдэх хүрээлэнд дуучин Төмөрийн дуулсан ардын уртын дуу “Дөмөн”-г сэтгэл хөдлөн сонирхож үүнээсээ сэдэвлэн сэтгэгдлээ тэмдэглэж хэдэн өдрийн дараа “Дөмөн” гэдэг уянгын сайхан шүлэг бичжээ... “Дөмөн” гэдэг шүлгийг ажиглахад ардын дуу дөмөнгийн зарим үг хэллэгийг авч мөрийн төгсгөлд зээ, янагшьюу, янцгааюу гэх мэтийн үгнүүдийг хэрэглэсэн... Мөн Гэсэрийн тухай аман үлгэрээс үндэслэж “Буйдан баатар” гэдэг бяцхан найраглал бичжээ. Энэ найраглал нь шүлэглэсэн үлгэрийн хэлбэрээр аятайхан хийгджээ” (2017:6,9,10) гэснийг утга зохиол судлаач, доктор Д.Цэдэв “... Гэсэрийн туужийн тухай үлгэрээс үндэс уламж авч “Буйдан баатар” хэмээх үлгэр-найраглалыг бичсэн юм” (1969:636) гэж мөн давхар баталсан байна. “Дөмөн”-гийн талаар бас утга зохиол судлаач П.Батхуяг “... Яруу найраг хамгийн төгс зохист найрсал юм” гэж Жексон Бэйтийн 1963 онд хэвлүүлсэн “Жон Ките” номонд тэмдэглэжээ. Тийм чанарын илрэл Гомбын Сэр-Одын яруу найрагт бий. Маргаагүй бол “Дөмөн”-г санацгаая. Тэр цагийнхаа дуучин охины дуулахыг харжээ. Сэтгэлийн учиг ялимгүй алдуурсан байх магадлалтай. Энэ бол нэг тал нь. Харин нөгөө тал нь “Дөмөн”, яруу эгшиг, морин хуур, дуу эгшгийн найрсал. Энэ л хоёрын халз тулах агшинд тэр шүлэг бичигдэх бүх сайн үр найрсан бүрдэнэ” (2021:209) хэмээн тэмдэглэжээ.

“Товчхондоо аль ч үеийн утга зохиолын хооронд бие биедээ нөлөөлсөн харьцаа холбоо ямагт байдаг. Жишээ нь: Манай бичгийн утга зохиолын анхны томоохон дурсгалуудын нэг, Монголын утга зохиолын тулгын гурван чулуу, сүмбэр гурван оргилын нэг хэмээн тооцогддог алдарт “Нууц товчоо” 1240 онд зохиогдохдоо, холбоо үг /шүлэг/, ардын дуу, домог, зүйр цэцэн үг, хууч яриа гэх мэт аман зохиолынхоо баялаг өв сан дээр тулгуурлан түшиглэж, түүнийгээ бүтээлчээр шинэтгэн, баяжуулан хөгжүүлж ирсэн бол өөрөө /”Нууц товчоо”/ хожуу үеийнхээ Монголын түүх, уран зохиолын бүх текстүүдэд язгуур эх сурвалж, үнэлж баршгүй суурь уламжлал болж өгсөн юм” (Энхбаяр, 2019:134).

Аливаа уран бүтээлийг ямар нэгэн зүйлээс сэдэв, санаа авч бүтээдэг нь мэдээжийн тодорхой ойлголт бөгөөд уран бүтээлийн санаа, сэдэв олж авах энэхүү үйлдэлтэй холбогдох баримт жишээг Монголын орчин үеийн уран зохиолын туурвил зүйн сан хөмрөгөөс хэдэн зуугаар нь олж болно²². Орчин үеийн утга

²² “Зохиолын сэдвийг ямар ч зохиолч амьдралын гүнээс шилж авдаг байна... Зохиолын сэдвийг олон янзын юмнаас сэдэж болох боловч заавал үзсэн сонссон зүйлээсээ л сэдэх нь ашигтай ... (Ч.Лодойдамба), ... Зохиолч хүн амьдралын гүн дотор явж байхдаа аливаа содон юмыг ажиж дандаа ургуулан бодож явдаг байна. (Д.Мягмар), ... Сэтгэлд хоногшиж үлдсэн багын дурдатгалаас уламжлан сэдэж зохиол бичих явдал ч бий. (Л.Ванган), ... Бусдын ярианаас санаа авч лавшруулан судалж зохиолынхоо сэдвийг шилж авах явдал ч бий. (Д.Мягмар), ... Амьдралдаа үзсэн, хүнээр яриулсан зүйлээс сэдэвлэн бичихэд гайгүй болоод байх шиг санагдах юм. (Л.Удвал), ...Ц.Цэдэнжав “Хаврын урь” романыхаа сэдэв материалыг Онон, Ерөөгийн нэгдэлд таван жил ажиллахдаа олж авсан байна..., -Хэрэв би уран үгсийн чуулганаар говь нутагт яваагүйсэн бол, хэрэв би Гурванбумбууд тэмээчин Сүхбаттай уулзаж ярилцаагүйсэн бол “Сэгс Цагаан Богд” гарахгүй байсан юм гэж Д.Пүрэвдорж ярьж билээ. ... Зохиолоос санаа авч зохиол бичих явдал ч бий. Гэхдээ тэр нь хуулбар биш бүтээлч байх шаардлагатай” (Жамсранжав, 1975:103-107, 243).

зохиолын ерөнхий онолын бүтээлд “Сэдэв нь зохиолын агуулгаас урган гарах бус харин агуулга нь сэдвээсээ урган гардаг буюу тэрхүү зохиолын агуулгыг бүрдүүлж түүнд орох зүйлсийг төлөвлөн тогтоож өгдөг.. Нөгөө талаар ерөөс аливаа зохиол бүтээлийн сэдэв нь зохиогчийнхоо амьдралын хэвшил, эрхэлдэг ажил хөдөлмөр, боловсрол, мэдлэг, ертөнцийг үзэх үзэл, гэр бүлийн болон бага насны хүмүүжил, сэтгэцийн хэв шинж, темперамент, үзэж өнгөрүүлсэн амьдралын туршлага, нас, хүйс, өдөр тутмын ахуй амьдралын зан заншил, дадал зуршил зэрэг олон хүчин зүйлээс боловч тэр дотроос онцгойлон хамааралтай нэг детерминант /шалтгаант холбоо/ зүй тогтол байдаг нь зохиогчийн үзэж өнгөрүүлсэн амьдралын туршлага, туулсан замнал нь байдаг” (Энхбаяр 2019:105-106) хэмээн онцлон тэмдэглэжээ.

Бидний ажиглалтаас үзвэл тухайн зохиогч чухам ямар зүйлээс сэдэв санаа авч бичсэнээ бүтээлийнхээ гарчиг болгох²³, бүтээлийн гарчгийн дор тусгай тайлбар болгож дурдах²⁴, эсвэл бүтээлийнхээ эцэст төгсгөлийн үг маягаар оруулах²⁵ зэрэг янз бүрийн арга, хэлбэрээр ил тод илэрхийлсэн зүйл цөөнгүй тохиолдож байгаа нь зохиолчдын уран бүтээлийн туршлага, туурвил зүйн түүхэн замнал, судлал шүүмжлэлийн арга зүй, тэрчлэн Монголын уран зохиолын гадаад, дотоод харилцаа холбооны хувьд ч гүнзгийрүүлэн судлууштай, сонирхолтой баримт хэрэглэгдэхүүн болох юм. Сэдэвлэсэн зохиолыг бусад орны уран зохиолын сан хөмрөгөөс ч олж болох ажээ.²⁶

Үүнээс гадна тухайн зохиогч бусад уран бүтээлчийн зохиол бүтээл болон урлагийн өөр төрөл зүйлийн бүтээлээс ч бас сэдэв санаа авсан тухайгаа янз бүрийн арга замаар илэрхийлсэн байна.

²³ Нацагдорж, Д. (1955). Туурганы зургийг үзвэл. - Д.Нацагдорж. Зохиолын түүвэр. Содном, (Б). (эмх.). Дамдинсүрэн, Ц. (ред.). Улаанбаатар. 49; Өлзийтөгс, Л. (2000). Борооны үнэртэй навч номын завсраас унахад төрсөн шүлэг. Өлзийтөгс, Л. Тэнгэрт ургадаг модод. Шүлгүүд. Батбаяр, Д. (ред.). Улаанбаатар. 12 дахь тал; Батбаяр, Л. (2020). Хайртай хүү минь хай скүүл-ээ төгсөөд “хамт авахуулсан зураг”-аа хараад бичсэн шүлэг. Батбаяр, Л. Амьдралын гудамжаар. (Шүлгийн түүвэр). Улаанбаатар. 47.

²⁴ Баянтунгалаг, Д. Тайланд бүсгүй (Зураг хараад олсон шүлэг). Баянтунгалаг, Д. (1988). Үгийн эгшиг. Сүрэнжав, Ш. (ред.). Улаанбаатар. 49; Барамсай, Ж. Айдас. “Анекдотоос сэдэвлэв”. Барамсай, Ж. (1991). Биегүй сүүдэр. (Шог, хошин өгүүллэгүүд). Энхбат, Ц. (ред.). Улаанбаатар, 40-42; Хишигжаргал, П. Лусын зүүд. (Тохиолдол жишээ, үйлчлүүлэгчийн зүүднээс сэдэвлэв). Хишигжаргал, П. (2022). Эртний сайхан орон. Яруу найргийн цоморлог. Оюунханд, Б. (ред.). Улаанбаатар. 121. Б.Явуухулан. Где я родился. *По мотивам американских стихов*. Явуухулан, Б. (1960). Лирика. Москва.

²⁵ Сүглэгмаа, А. Гивлүүрт могой (Зохиолч Б.Ойдовын “Айн Жалудын цавчилдаан” туужийн дүрүүдээс сэдэвлэв). Сүглэгмаа, А. (2016). Хайрын гумуда. Улаанбаатар. 51-54; Өлзийтөгс, Л. Бурханы ил захидал. Найз Н.Ганцэцэгийн цахим шуудангаар илгээсэн мэндчилгээний ил захидлыг хүлээн аваад бичсэн шүлэг. Өлзийтөгс, Л.(2018). Ганцаардлын дасгал. Шүлгүүд. Аюурзана Г.(ред.). Улаанбаатар. 49; Хишигжаргал, П. Амьдрал. Найз охиныхоо ярианаас сэдэвлэв. Хишигжаргал, П. (2022). Эртний сайхан орон. Яруу найргийн цоморлог. Оюунханд, Б. (ред.). Улаанбаатар. 66.

²⁶ “Яруу найрагч Гулниса Имин “Мянган нэгэн шөнө” зохиолоос сэдэвлэсэн яруу найраг бичсэнээсээ болж” салан тусгаарлах үзлийг сурталчилсан” гэх үндэслэлээр 17 жил хагасын ял сонсчээ”. - Хятадад 100 гаруй зохиолч хоригдож байна. **Эх сурвалж: Guardian.** - NEWS.mn. ISUU. Дэлхий/Мэдээ. 2024.05.02.

Ер сэдэвлэсэн зохиолд холбогдох ажиглалт дүгнэлтийг уран зохиол судлаач, шүүмжлэгчдийн судалгааны бүтээлээс хялбархан олж болох бөгөөд энэ удаа зөвхөн нэг судлаачийн нэг бүтээлээс гүймэгхэн түүвэрлэсэн зарим жишээ баримтыг дор товчлон үзүүлэв²⁷.

Тэрчлэн сэдэвлэсэн зохиолын жишээ баримт нь уран зохиолын төрөл зүйлээс халин урлагийн бусад төрөл зүйлийн дотор ч бүртгэгдсэн байна. Жишээлбэл “Тал нутгийн аялгуу” хөтөлбөрийг “Монголын нэг өдөр” бүтээлээс сэдэвлэн хийжээ²⁸.

Сэдэвлэсэн зохиолыг дотор нь уран зохиол болон ардын аман зохиолоос сэдэвлэсэн хэмээн ялган хэлэлцэж бас болох юм.

Шууд бус хуулбарласан зохиолын нөгөө нэг хэв маяг болох элэглэсэн зохиолыг дотор нь хуулан элэглэсэн ба эвлүүлэн элэглэсэн хэмээн ангилж болно.

Нэгэн тодорхой зохиолын агуулга, утга санаа, үйл явдал, үйл хөдлөлийг өөр цаг үе, өөр орон зайд шилжүүлэн зохиомжилсныг хуулан элэглэсэн зохиол гэж үзлээ. Үүнд:

А.С.Пушкин. Сказка о рыбаке и рыбке (1833)

А.С.Пушкин. Алтан загасны үлгэр (Орчуулсан Ц.Дамдинсүрэн, 1938)

Ж.Барамсай. Орчин үеийн алтан загасны үлгэр (1977)

Ж.Барамсай. Орчин үеийн алтан загасны үлгэр²⁹ (1987)

Ч.Лодойдамба. Тунгалаг Тамир (Роман)

Б.Цэнддоо. Ерээд оны Тунгалаг Тамир (*Элэглэл тууж*)

М.Билэгсайхан. Эрчүүдээ өмөөрч бичсэн шүлэг

Д.Цээсэд. Яруу найрагч Мөнхөөгийн Билэгсайханд

Тэрчлэн Д.Нацагдоржийн “Хуучин хүү” (1930 он) өгүүллэгийг Д.Батжаргал, Б.Батчимэг, С.Баяр, А.Мөнхтуяа, Төмөрөө³⁰, Д.Цэрэн, Хандаа нар; Д.Пүрэвдоржийн

²⁷ “Б.Смирнов “Учиртай гурван толгой” дуурь, “Амарсанаа”, “Мандхай цэцэн хатан” зэрэг хөгжимт драмын жүжгийн хөгжмийг бичилцжээ. Тэдгээр нь ардын аман зохиолоос иш үндэстэйгээрээ онцлог билээ. ... Дөчөөд оны үеийн яруу найрагчдын уран сайхны эрэл, уран сэтгэмж, уран бүтээлд үлгэр туульс хүчтэй нөлөөлж байжээ. Үлгэр туульсаас санаа авч П.Хорлоо “Хулсан ташуур”, Д.Даржаа “Аламсан хууртай хүүхэн”-ийг бичсэн байна. М.Чимэд “Цагаан тэмээт Өлзий”, Б.Бааст “Балчин хээр” зэргийг үлгэрийн хэлбэрээр бичжээ. Д.Тарва ардын шог яриа, хошин үлгэрээс санаа авч “Дэмбэрэлдорж”-ийг бичжээ. Энэ нь Ц.Дамдинсүрэнгийн “Толь Гэндэн”-г санагдуулдаг билээ. Дон Жуаны домгийг европын олон орны яруу найрагчид уран бүтээлдээ ашиглаж ирсэн шиг Бэлэнсэнгэ мэтийн шог яриа, хошин үлгэрийг манай яруу найрагчид уран бүтээлдээ ашиглаж иржээ... Эртний домгоос сэдэвлэн бичсэн Б.Ринчений “Бэр цэцэг”, П.Хорлоогийн “Алтан зоос” тийм болсон... Д.Намдаг, “Гэсэрийн тууж”-ийн гурван хувилбарыг зэрэгцүүлэн уншиж судлаад, түүний Шарай голын гурван хаан бүлгийг нь жүжгийн зохиол болгохоор сонгон авчээ. Гэхдээ түүнийг “Гэсэрийн тууж” дотроос яг хуулчихаж болохгүй байв. Харин түүнээс сэдэвлэн уг туужид гарч буй үйл явдлын заримыг хураангуйлан, заримыг дэлгэрүүлэн, зөрчил тэмцлийг өрнүүлэх газар нь өрнүүлж, зангидах газар нь зангидаж, жинхэнэ өөрийн арга барилаар найруулан бичсэн байна” (Жамсранжав, 1985:13, 57, 156).

²⁸ МҮОНРТ-ийн МНВ “Монголын мэдээ” сувгийн 2024 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн мэдээнээс.

²⁹ Шог зохиолч Ж.Барамсай “Орчин цагийн алтан загасны үлгэр” сэдвээр хоёр өөр өгүүлэмж бүхий хуулан элэглэсэн зохиол бүтээсэн байна.

³⁰ “Монголын утга зохиолын салбарт орж ирсэн ч хараахан олны хүртээл болж амжаагүй нэг төрөл бол Ремейк (Remake) юм. Кино уран бүтээл, хүүрнэл зохиолын төрөлд хуучны уран бүтээлийг шинэчлэн найруулах байдлаар “Одоо байгаа уран бүтээлийн

“Сэгс Цагаан Богд” (Тэмээчин бүсгүйн захидал) найраглалыг Ч.Чагнаадорж болон өөр хоёр зохиогчийн тус тус хуулан элэглэсэн бүтээлийг энд оруулж болно.

Хуулан элэглэсэн зохиолын хэв шинжийг дараах жишээгээр төлөөлүүлэн үзүүлье. Үүнд:

Ч.Лодойдамба. Тунгалаг Тамир

Олноо өргөгдсөний дөтгөөр оны зуны эхэн сарын нэгэн өдөр Их Тамирын хойгуур гарсан замаар гуч орчим насны хар хүн нэлээд ачаатай морин тэрэг хөтлөөд явж байв. Нар салхинд гандаж, хир хөлсөнд нэвтэрч урагдсан дээлээ есөн өнгийн юмаар нөхсөн болохоор ямар эдээр хийсэн нь мэдэгдэх аргагүй ажээ.

... Энэ хүнийг Эрдэнэ гэдэг. Засагт ханы хошууны Олгонууд отгийн хүн. Уулаас эцгээс ах дүү хоёул бөгөөд багадаа өнчрөн айл дамжин зарагдаж бор хоног өнгөрүүлэн явжээ.

... Эрдэнэ бусад хүн шиг зовохдоо зовж, өлсөхдөө өлсөж, баярлахдаа баярлаад, хорсохдоо хорсоод амьдарч болох байжээ. Гэтэл шинээр ширээ залгасан засаг хаан Гомбожавын зан авир ширүүн, ард олныг зовоох нь хир хэмжээнээс хэтрэхэд чуулган дарга, монгол манж зургааныг дамжин заргалдав.

Гэвч ноёнттой өшөөтэй бол хонгогүй, нохойтой өшөөтэй бол хормойгүй гэдэг дэмий үг биш болохоор Гомбожав хошууны хөрөнгөөр хөлөө хүрэх газар бүхэнд хээл хахууль цутгаж байгаад эзэн ноёнттойгоо харгалдсан тэрсүүд албатыг Улиастайн бат гүнд орхив.

... Эрдэнийг нутагтаа очиход нь хорссон хааны хавчлага байж суухын аргагүй болоход нь албан татвар, аль нэгд өчүүхэн хөрөнгө хамж өгөөд ганц морин тэргэнд юмаа ачиж Богдод мөргөхөөр эхнэр хүүхдээ дагуулан хүрээний зүг зам хөөжээ.

Дүү нь Төмөр гэгч хүн бий. Арван зургаан насандаа шилийн сайн эрчүүдтэй нийлж удалгүй эрмэг зориг, эр чадал ухаан санаагаар гайхагдсан «Засагт ханы цахиур Төмөр» гэж алдаршин халх дөрвөн аймаг, шавь тавд домог мэт яригддаг болжээ.

Өнөөгөөс гурван жилийн өмнө Төмөр ахындаа гүн шөнө үл таних хоёр хүний хамт ирж уулзаад үүр шөнө салахын үед явжээ. Тэгэхдээ цоохор ембүү, оросын цагаан хааны цөлхөөв гучаадын хамт өгчээ.

Түүнээс хойш ах дүү хоёр нүүр учраагүй зөвхөн л сургаар амьд мэндээ мэдэлцэж байжээ. Харин сүүлийн жил гаруйн дотор Эрдэнэ дүүгийнхээ тухай ямар ч сураг сонссонгүй.

Эх сурвалж: Лодойдамба, Ч. (2005). Тунгалаг Тамир. XX зууны утга зохиолын дээж суварга. V. Улаанбаатар. 559.

Б.Цэнддоо. Ерээд оны Тунгалаг Тамир (Элэглэл тууж)

Григориан тооллын нэгэн мянга есөн зуун ерээд оны август хэмээх зуны сүүл сарын эхний декад, Архангай аймгийн Их Тамир сумын өмнөх засмалаар гуч шинэ хувилбар”-т тулгуурлан хошин маягаар өрнүүлэн өгүүлдэг. Гар урлалаас эхлээд урлагийн бүхий л төрөл зүйлийг шинэчлэн бүтээж болдог болохоор Ремейк бүх л урлагт бий. Эх зохиолоос ашиглах, сэдвийг өөрчлөх, үйл явдлын өрнөл, нөхцөл байдлыг өөрчилж болдгоороо Ремейк үзэгч уншигчдад сонирхолтой байх нь бий... Монголд нийтлэлч Б.Цэнддоо “Тунгалаг Тамир” романы шинэчилсэн хувилбарыг гаргаж тавьсан нь уншигчдын сонирхлыг ихээхэн татсан байдаг” (Төмөрөө, 2025:23).

орчим насны хар хүн нэлээд ачаатай бяцхан чиргүүл зүүсэн хуучивтар “ГАЗ-67” жолоодон явж байв. Элэгдэж хуучирсан торгон савхин цамцаа янз бүрийн өнгөөр олон дахин будуулсан тул анх ямар өнгөтэй байсан нь үл мэдэгдэнэ.

Энэ хүнийг Эрдэнэ гэнэ. Говь-Алтай аймгийн Тайшир сумын хүн. Ойрноос нэрээ “Нью боржигин овогт мистер Эрдэнэ” хэмээн бичих болжээ. Эрдэнэ өмч хувьчлалаас болж аймгийнхаа засаг даргатай заргалдаад “коррупцитай өштэй хүн мөнгөгүй, ковбойтой өштэй хүн амьгүй” гэдгийн үлгэр болж дийлдээд арга барагдан Улаанбаатар орж бизнес хөөх, далимд нь өмч хувьчлалын комиссын Гэрэлчулуунтай уулзах гэж явж байгаа нь энэ.

Эрдэнэ эцэг, эхээс хоёул. Дүү Төмөр нь аль багадаа сайн эрсийг даган “загалмайлан эцэг” болно гээд сургуулиа орхин замын машинд дайгдаад хот руу арилжээ. Төмөр нэг хэсэг вокзал хавиар “нүүрсчин” хийж байснаа улмаар Улаан-Үд, Эрэн хоёрын хооронд гахай чирж овоо цулайгаад, сүүлдээ автомашины хулгайгаар дагнан занимаалах болж, Варшав, Москва, Улаанбаатар, Бээжин, Сингапурыг холбодог үндэстэн дамнасан том мафийн тэргүүн болж олонд “алмаз” Төмөр хэмээн алдаршаад бриллианттай гараар салаавч өгдөг нэгэн болжээ. Төмөр ноднин зун орос, хятад хоёр гангстерийн хамт ахындаа ирж зуугаад юань, хэдэн доллар, таван шил “Рояль” спирт орхиод явжээ. Түүнээс хойш үхсэн амьдын сураг гарсангүй.

Эх сурвалж: Цэнддоо, Б. (2001). Ерээд оны Тунгалаг Тамир. (Элэглэл тууж). Хоёрдахь хэвлэл. Баабар, Б. (ред.). Улаанбаатар. “Т&U Printing” хэвлэх үйлдвэр. 82.

Эвлүүлэн элэглэсэн зохиолыг мөн цааш нь зохиолын зохиомж, хэсгээр болон зохиолын нэр, гарчгаар эвлүүлэн элэглэсэн гэж ялгаж болно.

Нэгэн тодорхой зохиогчийн зохиолын хэсэг болон тухайн зохиолчийн бичлэгийн хэлбэр, хэв маяг, өвөрмөц онцлогийг дуурайн хэрэв тухайн зохиогч, яруу найрагч бичвэл ингэж бичих байх гэсэн маягаар элэглэсэн зохиолыг эхний хэв шинжид хамааруулав. Жишээлбэл:

П.Бадарч. Элэглэл шүлгүүд. (Наадам болоод шинийн шөнийн тухай найрагч нөхөд ингэж л бичих болов уу)

Т.Галсан. Сансарт монгол хүн ниссэн тухай сайхан мэдээ дөнгөж сонсуугаа яруу найрагчид үзгээ шүүрнэ яг л иймэрхүү шүлэг бичигцгээнэ.

Эл хэв маягт Г.Баярхүү, Т.Галсан (анхны цас, наадмын тухай сэдвээр хоёр элэглэл), С.Дамдин, Даг.Жамьян, Д.Пүрэвдорж, Б.Төмөртоогоо (өндөр хүчдэл, чөлөөт цаг, өөрчлөн байгуулалтын тухай сэдвээр гурван элэглэл), Д.Цоодол, Д.Цээсэд (сууц өмчлөгчдийн холбоо, энэ цаг үеийн талаарх хоёр элэглэл) нарын бүтээлүүдийг тус тус оруулж байна.

Энэхүү хэв маягийн зохиолуудыг дараах бүтээлээр төлөөлүүлэн жишээлж үзүүлье. Үүнд:

Б.Төмөртоогоо. Өндөр хүчдэл

“Өндөр хүчдэл”-ийн тухай яруу найрагчид яаж бичихийг элэглэн бичсэн нь

Ж.Бадраа

Эх орны минь хөгжлийг тодруулах гайхамшиг
Энэхэн насаараа дуулж явах өндөр хүчдэл ээ хөө
Ээ чи минь суврагаланхан сүндэрлэх шон бүрдээ
Ээ чи минь эв хамтыг тээж яваа ч юм уу даа.

Ц.Гайтав

Заавал чи
Гурванбогдод минь оч гэж
Заяа нь би өндөр хүчдэлийн шонд тушаахгүй
Хаана очих хэрэгцээ байна тийшээ л явж байвал
Хангай говь аль нь ч над хамаа алга.

С.Дашдооров

Бас тэгээд зүгээргүй
Мангар Дамдингаа
Монтёр болгоё гэж нэг бодсон юм.
Байдал төрхий нь
Харж байгаад
Ярилцъя гэж шийдсэн юм.
Дэлгэр хангайдаа
Илч гэрэл түгээнэ гэхээс
Өөрөө би хөөрсөн юм
Дэмид өвгөний Саран охинтой
Шонгоос нь ч гэлээ
Суулгалцана гэж бодсон юм.

Ш.Дулмаа

Уяхан чинийхээ хайрыг
Өр зүрхэндээ хямгадаж
Уул талынхаа хязгааргүйд
Илч, гэрэл түгээж яваа
Ерийн нэгэн монтёр билээ би
Ертөнцийн нэгэн ажилчин билээ би

Д.Нямаа

Өргөн говийн хүн ардын зүг
Өндөр хүчдэл яарч явна
Их газрын чулууны зүг
Энэ жил
Оюутнуудын барьсан хашааны зүг
Баянхайрханд байгаа адууны минь зүг
Бас тэмээдийн зүг
Өргөн талаар алхан алхан
Өндөр хүчдэл яарч явна

Д.Пүрэвдорж

Өр зүрхэндээ хайрлаж явахад
Өвлийн чулуу нь бүлээн байдаг
Эрээн ууландаа өндөр хүчдэлийн
Энэ шонгуудыг дагуулж очъё гэсэн юм

Ш.Сүрэнжав

Алаг морьтой Дандарын давхиж явсан талаар

Арвын “Б”-гийн Цэндээгийн саналаа өгсөн газраар
Жирийж байгаа энэ олон шонг
Жирийн хүн-Зөвлөлтийн хүн босгосон юм.

Б.Цэдэндамба

Шар нүд, ямаан сахалтай
Шанаа нь хууз буриад өвгөн
- Хөвүүн чи монтёр болчихоод
Хүрээд ирэх нь энэ үү гэж
Өргөн хөвчийн модон дотроос
Өндөр дуугаар асуусан юм.

Эх сурвалж: Төмөртогоо, Б. (1983). Сарны цас.
Дашдэндэв, С. (ред.). Улаанбаатар. 47-49.

Сүүлийн хэв маягт нь зохиолч, яруу найрагч, жүжигчин зэрэг төрөл бүрийн уран бүтээлчдийн ном зохиол, бүтээл туурвилын нэр, гарчгаар эвлүүлэн зохиомжилж элэглэсэн болон ерийн зориулал шинжтэй зохиолыг хамааруулж байна. Үүнд Д.Баянтунгалаг, Б.Ваанчиг, Т.Галсан, Ч.Сувдаа, Ш.Сүхбаатар, Д.Сэнгээ, Б.Төмөртогоо, Д.Цээсэд нарын бичсэн элэглэлийг оруулж болох бөгөөд ийм хэв маягийн зохиолуудыг дараах бүтээлээр төлөөлүүлэн жишээлж үзүүлье.

Үүнд:

Д.Баянтунгалаг. Яруу найрагчдын тухай мөчлөг шүлгүүд

Д.Пүрэвдоржид

Хэзээнээс таныг үгсийн их адуун сүрэгтэй гэх юм
Хэрэг болсон цагт нөхрийн чанар танигдана гэж
Эрх л багын нутаг “Эрээн ууландаа” адуулж өссөн
Эрдэнийн дээд хүлэг морио шилэн хөтөлж
“Хар цас” зүрхэнд унасан гал мэсийн аюул дундуур
Хаттай ган үзгээ агсаад,
“Хөх даалимбан тэрлэг”-гэй хатируулж явсан гэх юм.
Дараахан нь та алтан шар замын эрэлд мордож
Дархан энхийн фронтод үгсийн эрдэнэ уудлан
“Сэгс цагаан богд”-ын тэмээчин бүсгүйтэй отрын аянд
Сэтгэл зүрхээ холбож “хээрийн цай” чанасан гэв үү?
“Ширмэн цөгц” шүтэж явсан
“Шарлингийн хар Хас”-ыг
“Жигүүрт цагаан гэрт” шинэ амьдралтай золгуулж
“Зэсэн уулын бичээс”-ээр “Хорьдугаар зуунд” найраг шагласан
Дэндэв гуайн хүү уул нь Өвөрхангайнх!
Дээр нь би, “Сэгс цагаан богд”-ын тэмээчин гэж нэмье!

1981

С.Дашдооровт

I

Таны нутаг Улаанбаатар ч арай биш ээ “Говийн өндөр” сөн бил үү?
Танил нэгэн бүсгүй сэтгэлд эргэлдэнэ. “Айлын хүүхэн Алгирмаа” юу даа
“Хойтон жилийн наадам” хүртэл зай ч байна даа, юу удах вэ дээ,
“Холын цэнхэр уулсын цаанаас” “Өндөр ээж” минь санаж суугаа, зав гарахгүй, юу яая даа...

II

“Дөшин жирэмийнхний наадам” дээр бригадын агент хэн гуайгаас
“Дөрвөлжин хайрцагтай “Хар морьт” хариулт мөнгөтэй атгаж

“Казбек” хэмээх тамхиар “Мангар Дамдин”-тай тамхилж
“Тал бид хоёр” уулзаагүй удаж дээ... гэж хөмсөг зангидаад
Та тэгэхэд бодлоо нэрж суулуу,
Танил нэгэн найрагч минь!

II. Бадарчид

“Морьд”-ын “Алтан тоос” сэтгэлд унана
Модод шарлах намраар “Хандармаа” санагдана
Их говийн “Гурвансайхан хөх уулын” бэлээс
“Ингэний буйлах сонсогдоод л”... тэр уяхан дуунд
“Зургаан мөнгөн мичид” яагаа ч үгүй цэцэглэн
Зуун дамжин тандаа би дахин төрье.
1981

III. Сүрэнжавт

“Шүүгээн дотор хот” урлахдаа та “Гар”-тай хүн.
Сүйрлийн дайныг зүрхнийхээ харууслаар ширвэхдээ “Гар”-тай хүн.
Дуу хайр хоёр үнэний тэнхээ гэвээс
“Дуулганд ургасан цэцэг” эсэн энхийн тэмүүлэл,
Найраг тээсэн сэтгэлийн гүүр хорвоогийн тэнхлэг гэвээс
Нартад “Миний дуулах ертөнц” гэж зүрхнийхээ сэрлийг уудлан
Найраг бичихдээ уянгын жигүүр дэлгэсэн “Гар”-тай хүн.
1981

Эх сурвалж: Баянтунгалаг, Д. (1988). Үгийн эгшиг.

Сүрэнжав, Ш. (ред.). Улаанбаатар. 73-76.

Ийнхүү Монголын уран зохиолын дотоод харилцаа холбооны хүрээнд томъёолсон дээрх ангиллын загварыг цааш үргэлжлүүлэн хийсвэрлэж, монгол уран зохиол ба гадаад уран зохиолын харилцан холбоо буюу уран зохиолын гадаад ба дотоод харилцаа холбоон дээр үндэслэн а/ монгол уран зохиолын, б/ гадаад уран зохиолын хэмээн цааш нь бас нарийсган ялгаж тодотгох боломжтой юм. Тухайлбал дуураймал зохиолын эхний хэв шинж болох даган дуурайсан зохиолыг цааш нь гадаадын ба Монголын уран зохиолыг даган дуурайсан, мөн хоёр дахь хэв маяг болох үлгэрлэн дуурайсан зохиолыг гадаадын болон Монголын уран зохиолыг үлгэрлэн дуурайсан гэх мэтээр тус тус ялгаж болно. Монголын уран зохиолын далд харилцаа холбооны хувьд бол түүний нэгэн хэв маяг болох харилцаат зохиол нь гадаадын аль нэг тодорхой уран зохиолтой ямар нэг харилцаа үүсгэсэн шинжтэй байж болох бөгөөд бидэнд одоогоор ийм баримт жишээ хараахан олдоогүй байна.

Энэ мэтчилэн өмнө болон одоогоор нэмэн бүртгэж цуглуулсан³¹ жишээ баримтад үндэслэж хийсвэрлэн таамаглавал Монголын уран зохиолын ил харилцаа холбооны нөгөө нэг хэв маяг болох хуулбар зохиолын шууд ба шууд бус хуулбарласан хоёр хэв маяг болон тэдгээрийн дотоод хоёрчлон салбарласан задаргаанд хамаарах хошоод хошоод дэд хэв маягуудыг мөн Монголын уран зохиолын ба гадаадын уран зохиолын эх сурвалжаар нь тус тус хоёрчлон ялгаж, нарийвчлан ангилах боломжтой хэмээн үзэж байна.

Тэрчлэн дээр дурдсан Монголын уран зохиолын гадаад дотоод харилцаа холбоонд хамаарах бүтээлүүдийг цааш нь аман зохиолын ба аман зохиолын бус гэх зэргээр ялган нарийвчилах ч боломжтой юм.

³¹ Мөнх-Амгалан, Ю. (2024). Уран сайхны эхийн талаар нэмэн өгүүлэх нь. Эрдэм шинжилгээний бичиг. Орхон Их Сургууль. 24. 210-235; Мөнх-Амгалан, Ю. (2025). Уран сайхны эхийн талаар дахин өгүүлэх нь I. Эрдэм шинжилгээний бичиг. Орхон Их Сургууль. 25. 270-291.

Ном зүй

- Баатар, Я. (2005, 2015). *Б.Явуухулангийн “Би хаана төрөө вэ?”: Судалгаа. Эх хэрэглэгдэхүүн. Сэтгэлгээ*. Улаанбаатар. Сан Франциско.
- Байгалсайхан, С. (2019). *Ц.Дамдинсүрэнгийн хүүрнэл зохиолын уламжлал*. Монгол Улсын төрийн гурван удаагийн шагналт, ардын уран зохиолч, академич Цэндийн Дамдинсүрэн. Байгалсайхан, С.(ред.). Улаанбаатар. 150-156.
- Байгалсайхан, С. (2020). *Хөриш гурван улсын соёлын харилцааны шинэ боломжууд*. Хэл зохиол судлал. XIII (45). 205-218.
- Батчимэг, Э., (2019). *Зураач М.Уранбэрхийн бүтээлийн утга агуулгад хийсэн судалгаа*. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал”. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Баяртөр, Б. (эмх.), (ред.). Улаанбаатар. 58-64.
- Батхуяг, П. (2021)..“*Монгол тууж*”-ийн зохиолын цаг хугацаа, орон зайн товч. Батхуяг, П. Эсээ оршил ... буюу элдэв эсээс... Баянжаргал, О. (ред.). Улаанбаатар.
- Баясгалан, Т. (2014). *Монгол Улсын нутагт дэлгэрсэн “Гэсэр”-ийн аман үлгэрүүд*. Хэл зохиол судлал. VII (39). 157-171.
- Буянзаяа, Ц. (2013). *Монгол уран зохиолын түүхэн товч*. Тэргүүн дэвтэр. Чулуун номноос хөлгөн сударт. (Уран зохиолын сэтгэлгээний хөгжлийн уламжлал шинэчлэл). Улаанбаатар.
- Гаадамба, Ш. (1989). *Утга зохиолын онолын үндэс*. Шархүү, А. (ред.). Улаанбаатар.
- Галбаатар, Д. (2012). *Уран зохиол*. Онол, түүх, шүүмжлэл. С.Дулам, К.Окада. (ред.) Улаанбаатар.
- Галбаяр, Г. (2006). *Эртний Грек, Ромын уран зохиол*. Улаанбаатар.
- Галбаяр, Г. (2010). *Дундад зууны өрнө дахины уран зохиол*. Улаанбаатар.
- Галбаяр, Г. (2020). *Сэргэн мандалтын үеийн өрнө дахины уран зохиол*. Улаанбаатар.
- Ганбаяр, Г. (2024). *Бүжгийн урлаг бол хөдөлдөг яруу найраг*. “Өнөөдөр” сонин..7.3.А 7.
- Дамдинсүрэн, Ц. (1956). *Гэсэрийн туужийн гурван шинж*. Нацагдорж, Ш.(ред.). Улсын хэвлэл. Улаанбаатар. 38.
- Дамдинсүрэн, Ц. (1987). Монголын уран зохиолын харилцаа холбооны асуудалд. (Өгүүллийн эмхэтгэл). Ёндон, Д. (ред.). Хүрэлбаатар, Л. (эмх.). Улаанбаатар.
- Дашдорж, Д. (2017). *Г.Сэр-Од бол авьяаслаг яруу найрагч байсан юм*. Г.Сэр-Од. Дөмөн.
- Жаргал, Я. (эмх.), (ред.). Улаанбаатар. 4-13.
- Дулам, С. (1976). *Эртний дорно дахины уран зохиолын тойм*. Бадраа, Ж. (ред.). Улаанбаатар.
- Дулам, С. (1977). *Дундад эртний дорно дахины уран зохиолын тойм*. Базаррагчаа, Ц. (ред.). Улаанбаатар.
- Жамсранжав, Г. (1985). *Цаг үеийн дуудлагаар*. Мөнх, Ц. (ред.). Улаанбаатар.
- Загдсүрэн, У. (1977). *Жангарын туульс*. Монголын уран зохиолын тойм. Хоёрдугаар дэвтэр. (XVII-XVIII зууны үе). ШУА. Дамдинсүрэн, Ц., Цэнд Д. (ред.). Улаанбаатар. 205-236.
- Лхагва, А. (2009). *Дагдангийн Амгалан*. Монгол зураачид. Ариутган шүүсэн Э.Сонинтогос. Улаанбаатар. 18-23.
- Лочин, С. (1973). Суут хоёр “одны” ховор тохиол. “Утга зохиол урлаг”сонин. № 17 (862). 3 дахь нүүр.
- Лочин, С. (2019). *Монголын эртний уранзохиол*. (Эрт цагаас XX зуун хүртэл). Шүүдэглэсэн Г.Билгүүдэй, Д.Болормаа. УБ
- Лочин, С. (2024). *Өрнө дахины уранзохиол*. Аюурзана Г., Болормаа, Д. (ред.). Улаанбаатар.
- Лувсанвандан, С. (1973). *Монголын орчин үеийн уран зохиолын онол-түүхийн асуудалд*. (Өгүүллийн түүвэр). Мөнх, Ц. (ред.). Улаанбаатар.
- Лувсанвандан, С. (1987). *Монголын уран зохиолын дэвшил, социалист реализм*. Уран бүтээлийн арга, зохиолчийн өвөрмөц шинж. Тэргүүн дэвтэр. Цэнд, Д. (ред.). Улаанбаатар.
- Пүрэв-Очир, Б. (2008). *Сайн үйлсийг бүтээж салаа замаар явсан эрдэмтэн-зохиолч*. Улаанбаатар.
- Пүрэв-Очир, Б. (2013). *Их зохиолч Д.Нацагдоржийн зарим хувилбарт зохиолууд, тэдгээрийн онцлог*.

- Хэл зохиол судлал. VI (38). 119-127.
- Сампилдэндэв, Х., Боролзой, Д. (эмх.). (2001). *Удиртгал*. Монгол хошин шог ярианы дээж. Улаанбаатар. 3-21.
- Сумъяа, Д., Болормаа, Д. (2015). *С.Буяннэмэхийн яруу найргийн зохиолын тухайд*. Хэл зохиол судлал. VIII (40). 196-205.
- Төмөрөө. (2025). “Шинэ цагийн хуучин хүү” (Ремейк) - “Монголын үнэн” сонин. № 016 (24643). 23 дахь нүүр.
- Түдэв, Л. (1975). *Монголын уран зохиолын үндэсний болон нийтлэг шинж*. Ширэндэв, Б. (ред.). Улаанбаатар.
- Түмэнбаяр, С. (2011). *Нууц товчооны адуу*. Шүлэг, найраглал, өгүүллэг, тууж. Улаанбаатар.
- Хөвсгөл, С., Ариунчимэг, Д. (1998). Дорно дахины уран зохиолын түүхийн найруулал. Оюунбадрах, Д. (ред.). Улаанбаатар.
- Хүрэлбаатар, Л. (1989). *Сонгодог уламжлал, монгол яруу найраг*. Улаанбаатар.
- Цэдэв, Д. (1969). *Яруу найргийн урын сан*. Яргуй. (Залуу зохиолчдын түүвэр). Улаанбаатар. 62-64.
- Цэдэв, Д. (1973). *Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл*. (1920-40-өөд он). Тэргүүн дэвтэр. Лувсанвандан, С. (эрх.). Улаанбаатар.
- Цэнд, Д. (1972). *Монголын орчин үеийн уянгын яруу найраг*. (1921-1970). Лувсанвандан, С. (ред.). Улаанбаатар.
- Цэнд-Аюуш, Ш. (1975). *Удиртгал*. Монгол хошин шог яриа. Цэнд, Д. (ред.). Улаанбаатар. 3-10.
- Шинжлэх Ухааны Академи, Хэл Зохиолын Хүрээлэн. (2007). *Михайловоос Б.Өлзийсүрэнд бичсэн захидлаас*. Монгол уран зохиолын дээжис-108. Цаасан шувуу-II. 108-р боть. Улаанбаатар. 66-67.
- Шинжлэх Ухааны Академи, Хэл Зохиолын Хүрээлэн. (2007). *До.Цэнджаваас Д.Төрбатад бичсэн захидлаас*. Монгол уран зохиолын дээжис-108.
- Цаасан шувуу-II. 108-р боть. Уб., 2007. 130.
- Шинжлэх Ухааны Академи, Хэл Зохиолын Хүрээлэн. (1977). *Монголын уран зохиолын тойм*. Хоёрдугаар дэвтэр. (XVII-XVIII зууны үе). Дамдинсүрэн, Ц., Цэнд, Д. (ред.). Улаанбаатар.
- Энхбаяр, С. (2019). *Утга зохиолын ерөнхий онол, туурвил зүй*. Нэмэн засварласан дөтгөөр хэвлэл. Батсуурь, Г., Мөнхнаран, Т., Надмид, Б. (ред.). Улаанбаатар.

Abstract

This article expands the content and scope of the concept and term “Mongolian Literary Interactions”, first formulated by Academician Ts. Damdinsüren (1987) and classifies Mongolian literary interactions into external and internal; distinguishes external interactions into Eastern and Western; classifies internal interactions into covert and overt; classifies covert interactions into response literature and related literature; classifies overt interactions into imitative writings and plagiarized writings; within imitative writings, distinguishes between sequential imitative writing and example-based imitative writing; within plagiarized writings, distinguishes between directly plagiarized and indirectly plagiarized; within directly plagiarized writings, distinguishes between edited plagiarism and paraphrased plagiarism; classifies indirectly plagiarized writings into inspired and parodied; and attempts to explain these classifications with appropriate evidence.

This article thus offers new Mongolian terminology for identifying, analyzing, and discussing both original and unoriginal writing in Mongolian literary contexts. It is hoped that this new terminology for describing varying degrees of copied works will increase awareness in Mongolia about the plagiarism spectrum and ways to identify plagiarized writing.